

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-36

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/ 8-9

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Аудитын сэдэв батлах тухай/ 9-34

3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/ 34-36

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 04-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Чойжилсүрэн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Ж.Батжаргал, З.Мэндсайхан, Ж.Баясгалан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 92.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Аудитын сэдэв батлах тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Стратеги, төлөвлөлтийн газрын захирал Ц.Баярмаа, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Л.Мөнхцацрал, мөн хэлтсийн Бодлого, төлөвлөлт хариуцсан менежер Б.Баттуяа, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Батчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Батжаргал, Б.Түвшин, Г.Дамдинням, Д.Батлут, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан 11 цаг 34 минутаас 11 цаг 41 минутад түр завсарлав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд дүгнэлт хийх аудит хийж, дүгнэлт гаргах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 7

Бүгд: 23

69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагааны санхүү-гүйцэтгэлийн аудит хийх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Батбаяр, Ж.Баясгалан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, эрсдэлд орсон арилжааны банкууд дахь Төрийн сан, Засгийн газрын тусгай зориулалтын сангууд болон төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн байршуулсан хөрөнгө эрсдэлд орсон талаар санхүүгийн гүйцэтгэлийн аудит хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ тарифын зохицуулалтын өртөг, зардалд аудит хийх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Батбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, нефть боловсруулах үйлдвэрлэлийн үйл явц, зээлийн зарцуулалтад хяналт шалгалт хийх, аудит хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, үнэ тогтворжуулах зорилгоор төрөөс олгож буй татаас, нөхөн олговрын үйл явц, зарцуулалтын үр дүнд аудит хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 5
Бүгд: 23
78.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 19 гишүүн дэмжиж, 82.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Эм, эмийн хэрэгслийн агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүү-гүйцэтгэлийн аудит хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холболдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Б.Мөнхсоёл, Ж.Баясгалан, Б.Түвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, 86.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, хураамж, торгуулийн орлогын зарцуулалтад санхүүгийн аудит хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Баясгалан, З.Мэндсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын

дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Батжаргал, Х.Ганхуяг, З.Мэндсайхан, Д.Батлут нар үг хэлж, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагааны санхүү-гүйцэтгэлийн аудит хийх гэсэн санал дээр хөдөө аж ахуйг дэмжих корпорац гэдэг үгийг нэмэх гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг тусгаж “Аудитын сэдэв батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Д.Батлут, Г.Ганбаатар, З.Мэндсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Тогтоолын төслийн хугацааг 2024 оны 12 дугаар сарын 18-наар болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 16 гишүүн дэмжиж, 69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 23 гишүүнээс 17 гишүүн дэмжиж, 73.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 34 минут үргэлжилж, 25 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 34 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны хуралдаанд оролцвол зохих 25 гишүүнээс 13 гишүүн ирж, ирц 52 хувьтай байгаа учраас өнөөдрийн 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдаанд Тилеуханы Аубакир, Батмөнхийн Батцэцэг, Жамбалын Ганбаатар, Гонгорын Дамдинням, Банзрагчийн Түвшин, Ринчиндоржийн Батболд, Жадамбаагийн Баясгалан, Хассуурийн Ганхуяг, Загджавын Мэндсайхан, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Баатаржавын Мөнхсоёл гэсэн гишүүд бүртгүүлсэн байна.

Байнгын хороогоор 3 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Эхний асуудал Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард “Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоол,

Хоёрт, “Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төсөл.

Гуравд, “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн юм байна лээ.

Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал, Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварыг батлах асуудлыг хэлэлцье.

Цаглаварын төслийг та бүхэнд тараасан байгаа. Үүнтэй холбогдолтойгоор асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай”

Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 61.5 хувиар батлагдсан байна.

Протоколд Түвшин гишүүн, Батжаргал гишүүн, Мэндсайхан гишүүн, Баясгалан гишүүн нар дэмжсэнээр тэмдэглэе.

Төсвийн байнгын хорооны эхний асуудлаар цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

10.38 цаг

Хоёр дахь асуудал, “Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Д.Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Ц.Баярмаа Үндэсний аудитын газрын Стратеги төлөвлөлтийн газрын захирал, Л.Мөнхцацрал Үндэсний аудитын газрын Стратеги төлөвлөлтийн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Баттуяа Үндэсний аудитын газрын Стратеги төлөвлөлтийн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Бодлого, төлөвлөлт хариуцсан менежер, Б.Батчимэг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын аудитын менежер гэсэн ийм хүмүүс оролцож байна.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитораас 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 1302 тоот албан бичгийн хавсралтаар Төрийн аудитын байгууллагын 2025 онд хуулийн дагуу болон бодлогоор гүйцэтгэх аудитын сэдвийг батлуулахаар ирүүлснийг Байнгын хорооны гишүүдэд цаасаар болон цахимаар хүргүүлсэн байгаа.

Уг Төрийн аудитын байгууллагын 25 онд гүйцэтгэх аудитын сэдвийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав танилцуулна. 5 дугаар микрофон.

Д.Загджав: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллагын 25 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг боловсруулан Төсвийн байнгын хороонд хүргүүлж та бүхэнд танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд болон бодлогоор гүйцэтгэх 28 аудитын сэдвийг судалж бэлтгэн тэдгээрээс хуульд заасны дагуу хийх 17, бодлогоор гүйцэтгэх 11 аудитын сэдэв байна.

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаа буюу 25 оны 1 дүгээр сарын 25-аас 6 дугаар сарын 15-ны хооронд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, улс, орон нутгийн төсөвт байгууллага, тусгай сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлнэ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын газрын тосны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын, өрийн удирдлагын, Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичгийн хэрэгжилт, газрын тосны өр, өртөг нөхөх зардал баталгаажуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн зэрэг сэдвээр аудитыг гүйцэтгэнэ.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, болон улсын хөгжлийн 24 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд аудит хийнэ. Эдгээр аудитыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 18.1-д Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хурлын хянан хэлэлцэнэ гэж заасны дагуу нэгтгэн гүйцэтгэхээр төлөвлөвөө.

Төсвийн тухай хуулийн дагуу улс орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдвээр аудитыг улс, орон нутгийн түвшинд нэгдсэн удирдамжаар Өрийн удирдлагын тухай хуулийн хүрээнд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-25 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт сэдвээр аудитыг гүйцэтгэхээр боловсрууллаа.

Төрийн аудитын байгууллагын 2024-2027 онд гүйцэтгэх аудитын сэдвийн стратеги, харилцагч талууд болон иргэдээс ирүүлсэн санал, аудитын байгууллагаас гүйцэтгэсэн илрүүлэлтийн эрсдэлд суурилсан сэдвүүдийг нэгтгэн үнэлж, эрэмбэлэн холбогдох тооцоолол, судалгаанд үндэслэн төрийн аудитын байгууллагаас 2025 онд бодлогоор гүйцэтгэх 11, аудитын сэдвийг тодорхойлж, Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд хуулийн дагуу болон бодлогоор гүйцэтгэх сэдвээр ангилан аудитын сэдвийг боловсруулан хүргүүлсэн.

Төсөлд хүргүүлсэн аудитын сэдвээс гадна Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасны дагуу аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар тухайн орон нутагт 4-өөс илүүгүй аудитын сэдвийг бодлогоор төлөвлөж гүйцэтгэх болно.

Бид хуулиар хүлээсэн төрийн санхүү, төсвийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд стратегийн хэрэгжилт, тайлант онд дэвшүүлсэн зорилт, аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх, цаашид Монгол Улсын Их

Хурлаас баталсан хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлттэй өөрсдөдөө холбогдуулан төсвийг үр ашигтай, зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, түүнийг төлөвшүүлэхэд хариуцлагаа улам сайжруулж, иргэдийн амьдрал, нийгмийн хөгжилд дэмжлэг болгох сэдвээр аудитыг гүйцэтгэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэсэн сэдвийн, аудитын сэдвийн талаарх танилцуулга болон аудитын сэдэвтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Байна уу?

Түвшин гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуултаа асууя. Асуултаа асууж, үг хэлье. Энэ чинь ирцээрээ болчхож байгаа юм уу, яаж байгаа юм бол? Ганхуяг гишүүн. Батлут гишүүний нэрийг оруулъя.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд. Би эндээс асуулт болон санал хэлэх гэсэн юм. Өнгөрсөн парламентуудын Засгийн газрын тусгай сангууд дээр бид нар ажлын хэсэг байгуулж шалгах үйл ажиллагаа хийж байсан юм. Тэгээд санал, дүгнэлтээ ч дамжуулж амжаагүй, танилцуулж амжаагүй. Үүнтэй холбогдуулаад авах арга хэмжээний тухай асуудлуудаа ч хэлэлцэж чадаагүй ингээд дууссан юм байгаа юм.

Тэгээд энэ Засгийн газрын тусгай 25 сан байдаг юм л даа. Тэгээд энэ дээр ингээд хараад байхаар 14 дээр Ахмадын сан байгуулах тухай гээд дахиад ороод ирсэн байгаа юм. Ер нь бид нар төсвийн сахилга батын асуудал яриад байдаг. Төсөв бол харьцангуй гайгүй. Бид нар ингээд ил тод, нээлттэй тоонуудаа хараад явчихдаг. Гол асуудал хяналт багатай, зүгээр сайд нарын гарын үсгээр гардаг, зарлага хийгддэг журмаар зохицуулагддаг асуудлууд энэ сангууд дээр байгаад байгаа юм.

25 сангийн зөвхөн 8 нь хуультай, 8 нь хуультай. 17 нь, 17 нь хууль байхгүй, зүгээр яамны сайдын журмаар зохицуулагддаг, зарцуулагддаг. Тэгээд энэ асуудлыг цаашдаа Байнгын хорооны дарга бид нар энэ сангуудтай холбоотойгоор ажлын хэсэг байгуулж, энэ санал, дүгнэлт танилцуулж хууль, эрх зүйн орчинд нь нийцүүлэх, зарцуулалтыг нь ил тод, нээлттэй болгох энэ асуудлыг хийхгүй бол 25 сангаас НД-ын сан, ЭМД-ын сан хоёр бол харьцангуй бас ингээд шууд олон нийтэд зарцуулагдаад явдаг харьцангуй гайгүй байдаг.

Гэхдээ бас нөгөө эргээгээд мөнгийг нь аваачаад өөр банкнуудад байршуулдаг энэ тэр асуудлууд бий. ЖДҮ-ийн сан чинь 50 хувийн л эргэн төлөлттэй гэх мэтчилэн олон асуудлууд бий.

Тэгэхээр энэ дээр яг энэ сангуудтай холбоотойгоор ирэх жил яг энэ аудитын тайлан гарсны дараа бид нар энэ дээр нэг ажлын хэсэг байгуулж ажиллуулах ёстой гэж харж байгаа юм. Асуултынх нь Ахмадын сан гэдэг нь байгуулах гээд ороод ирчихсэн байгаа байхгүй юу. Энэ дээр би тайлбар авчихмаар байх юм. Ямар зорилгоор байгуулж байгаа юм, юунд зарцуулах юм, эх үүсвэр нь юу юм?

Ц.Даваасүрэн: Энэ ахмадууд та бүгдийг тойрогтоо ажиллахад энийг асууж байгаа байх. Энэ Ахмадын сан байгуулж ажиллуулах талаар Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д төсөвт байгууллагын тухайн цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, жил бүр төсөвтөө тусгаж зарцуулна гэж байдаг байхгүй юу. Энэ чинь бараг 20-иод жил болж байгаа. Тэгээд хэрэгждэггүй байхгүй юу. Муу ахмадуудаа бид нар бас бодох ёстой. Насаараа хөдөлмөрлөчхөөд өнөөдрийн энэ Монголыг бий болгочхоод ямар хэмжээний цалин авдаг билээ.

Гэтэл тэр 3 хувийн санг нь байгуулж өгөхгүй байгаад байгаа юм. Тэгээд тэр санг нь яагаад байгуулахгүй байна вэ гэдэг дээр аудит хийлгэе гэж Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, мөн Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нар энэ хүсэлтийг гаргаж оруулж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ санг яагаад та нар байгуулахгүй ахмадуудаа хулхидаад байна вэ гэдэг дээр гүйцэтгэлийн аудит хийх гэж байгаа юм. Ер нь Ганхуяг гишүүний хэлээд байгаа энэ Засгийн газрын тусгай сангуудын асуудал дээр бас анхаарах юм бий бий. Ер нь энэ Засгийн газрын тусгай сангууд, энэ Хөгжлийн банкны зээлийн төлбөрийн асуудал энэ тэр дээр ер нь бас ажлын хэсэг байгуулж дахиж шалгах хэрэгтэй.

Тийм учраас би Ганхуяг гишүүний саналыг хүндэтгээд ер нь бас Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж энэ сангийн хэрэгжилттэй танилцуулна гэж ингэж бодож байгаа.

Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая.

Одоо яригдаж байгаа сэдэв бол Монгол Улсын төсөв дэндүү их тэлсэн, данхайсан, энэ нь үндсэндээ үрэлгэн байдлыг зарим талаар бий болгож байна гэдэг яриа хэтэрхий их явагдаж байна.

Тийм учраас бид ер нь энэ төсвийн тал дээр үйл ажиллагаа явуулдаг, хянадаг, барьдаг энэ байгууллагууд нэгдсэн хүчээр энэ рүүгээ жоохон анхаарал чиглүүлж энэ төсвийн өсөлтийн хурдцыг хязгаарлаж болох юм уу, болохгүй юм уу, энэ бүтэц юмнууд нь зөв юм уу, ямар байгаа юм энэ тэр гэдэг дээр том дүгнэлт хийх зайлшгүй шаардлага байна уу гэж би бол ингэж хараад байгаа. Энэ тал дээр манай аудитын байгууллага ер нь ямар бодол санаатай байгаа юм бэ гэж. Нэг.

Үүн дотор томоохон зардал өндөржүүлээд болж өгөхгүй байгаа зүйл бол энэ зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах аргачлал, энэ заавар дүрмүүдийг эргэж харж, ямархуу байна вэ гэдэг юмаа үзмээр байна. Мэргэжлийн эрх авчихсан нөхдүүдийн боловсруулсан юман дээр магадлал хийгээд байгаа 3 хөгжлийн төв байгаад байх шиг байна. Эрчим хүчний хөгжлийн төв, Барилга хөгжлийн төв, Замын нэг төв байгаа билүү дээ? Энэ 3 төвийн хийж байгаа магадлал юмнууд ер нь бодитой юм уу, бодьгүй юм уу гэдэг юмыг яримаар байна. Зарим тохиолдолд анхны төсөвт өртөг бараг 3 дахин эд нар өсөж байгаа ийм тохиолдлууд гарч ирээд болж өгөхгүй байгаа.

Тийм учраас би энэ чиглэл дээр ер нь 2025 онд гол анхаарлаа чиглүүлж ажиллах ёстой юм биш биз дээ гэж. Энэ дээр аудит ямар байр суурьтай байна?

Гурав дахь зүйл, үгүй энэ төрийн байгууллагуудын чинь жигтэйхэн үйл ажиллагаа явуулдаг, орчин нөхцөлийг нь сайжруулна гээд баахан шинэ хөрөнгө оруулалтыг үндсэндээ 8 жил бид ахиу хийсэн. Тэр битгий хэл зарим салбар дээр бодлогын алдаа гарсан ч байж магадгүй гэж ойлгодог. Энэ ерөнхий боловсролын сургуулиудыг 1 ээлжид гэдэг ерөнхий зарчим, бодлого бариад хичээлийн байруудын өргөтгөл юмнуудыг маш их хийсэн. Энийг дагаад байр ашиглалтын тогтмол зардлууд, түүнийг дагасан үйл ажиллагааны урсгал зардлууд асар ихээр өссөн.

Тийм учраас энэ төрийн байгууллагуудын байр ашиглалт ямархуу байгаад байгаа юм. Илүү гарсан барьсан талбайтай элдэв бусын юм ер нь юу байгаад байгаа юм, ер нь яаж энийг зөв цэгцэд нь оруулах юм гэдэг асуудал Төсвийн байнгын хороо, аудит, энэ мэргэжлийн байгууллагууд энэ рүүгээ нэлээн анхаарал хандуулж байж л бид сая төсвийн өсөлтийн хурдыг сааруулах тухай, зөв болгох тухай асуудал яригдах болов уу гэсэн ийм л бодол байгаад байгаа юм. Бид углуургаар нь юм олж харахгүйгээр нийгмийн сэтгэл зүйг дагаад ганц, жижиг юман дээр ноцолдоод ямар ч үр дүн гарахгүй. Энэ төсөв яагаад ингээд байгаа юм гэдэг юмныхаа учрыг олж, тэрнийхээ чагт элдэв бусын юмнуудаа зөв тавих, хазаарлах, барих юмаа л бодохгүй бол энэ чинь цаашаа улам өсөөд явна гэж.

Одоо төлөвлөгдөөд ороод ирчихсэн зүйлээс 2 зүйлийг зориуд тодруулж асуумаар байгаа юм. Энэ Оюу толгойн зээлийн ашиглалт, зарцуулалтын үр дүнгийн тухай орж ирээд байгаа юм. Энэ Оюу толгой ер нь Монголд өгөөж их муутай байна шүү ний нуугүй үнэнийг хэлэхэд.

Тэгэхээр зэрэг энэ хийгдсэн гэрээний хэрэгжилт ямар байгаад байгаа юм? Ерөөсөө олборлоод гаргаж байгаа ашигт малтмал нь юу байгаад байгаа юм, тэрнээс Монголд юу үлдээд байгаа юм, тэр зээл аваад зээл нь ямархуу байдлаар зарцуулагдаад байгаа юм гэдэг юмнууд дээр иж бүрэн анхаарал хандуулахгүй эндээс орж ирж байгаа төсөвт орж ирж байгаа орлого юм чинь ер нь тун бага.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний тэр эхний асуусан төсөв ер нь ингээд өсөөд байгаа асуудал. Яагаад байна гэж, та бүхэн ч гэсэн орон тоогоо нэмсэн шүү дээ. Тэгээд яагаад ингээд ер нь байгууллага бүхэн дээр ийм юм яваад байна вэ гэдгийг тэгээд та нар ямар нэг дүгнэлт хийсэн юм байна уу гэж асууж байна.

Хоёрт, тэр төсөвт өртөг нөгөө ялангуяа энэ КОВИД-той холбогдолтойгоор энэ хийгдэж байгаа ажлуудын төсөвт өртгүүдийг дандаа 2 дахин өсгөлөө шүү дээ. Тэгэхээр энэ экспертизийн дүгнэлтийг аудитаар баталгаажуулж байгаа, танайхаар орж байгаа. Энэ хэр үндэслэлтэй юм бэ гэж байна?

Гуравдугаарт, энэ байр ашиглалтын асуудал. Сая бид нар төсөв хэлэлцэх явцад харахад энэ шинээр бий болсон, ялангуяа хүүхдийн тоо нэлээн өсчихсэн юм, 2 дахин өсчихсэн юм байна л даа 2000 оны эхэн үеийг бодоход сургуульд ордог хүүхдийн тоо 60-аад мянга байсан бол одоо 100 хэдэн мянга болчихсон. Тэгээд ингээд баахан сургуулийн байр, дотуур байр барьж, тэрний ашиглалт гээд ингээд үзэхээр нийт ашиглалтын зардлын өсөлтийн 30, 40 хувь нь шинэ байрууд

болсон байна гэсэн байна лээ. Энэ дээр та бүхэн ер нь энэ байр ашиглалттай холбогдолтой юу байна энэ?

Дөрөв, Оюу толгойн зээл, Оюу толгойн санхүүгийн үйл ажиллагаа төсөвт оруулж байгаа хувь нэмрийн тухай ярьж байна шүү дээ.

Тэгэхээр аудитын байгууллага шалгалт хийсэн байна лээ. Шалгалтын дүнг нууцын горимоор ирүүлчихсэн юм байна лээ. Энэ Оюу толгой гэдэг чинь тийм данхайсан том эрхтэй, бараг энд манай төрөөс давчихсан ийм газар байна шүү дээ. Бүх юм нууцаар явдаг, ил тод биш. Тэгэхээр би тэр аудитын дүгнэлтийг нууцын горимын дагуу Төсвийн байнгын хорооны гишүүддээ тарааж танилцуулна гэж бодож байгаа.

Ингээд асуултад нь хариулъя. 5 дугаар микрофон Загджав дарга.

Д.Загджав: Тэр Ганхуяг гишүүний асуултад сая дарга хариулчихлаа. Тэгээд Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ер нь энэ хэрэгжүүлэх гэж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн зураг төсөл, ТЭЗҮ, тооцоо, тооцооллыг бас нарийвчлан боловсруулах шаардлагатай байгаа. Маш олон арга хэмжээнүүд, төсөл, арга хэмжээнүүд, ТЭЗҮ, тооцоо дутуу байгаа тухай бас аудитын дүгнэлтэд бид бас хүргүүлсэн байгаа. Зарим энэ саяын дурдагдаж байгаа зүйлүүд дээр бол нэгдсэн төсвийн аудитын тайланд бид нар бас гүйцэтгэлээр нь тооцоод тэгээд зөвлөмж аргачлалаа өгчихсөн байгаа л даа.

Ц.Даваасүрэн: Байна шүү дээ. Төсөв энэ өсөөд байгаа шалтгааныг та нар юу гэж үзэж байна вэ гэж байна. Төсөвт өртөгт экспертиз хийсэн дээр та бүхэн аудит хийж байгаа энэ хэр үндэслэлтэй вэ гэж байна. Энэ байр ашиглалтын зардлууд өссөн байна, энэ ямар үндэслэлтэй байна вэ гэж байна. Асуудал байна шүү дээ.

5 дугаар микрофон.

Д.Загджав: Төсөв өсөж байгаатай холбоотой, тэр байр ашиглалтын зардал, гүйцэтгэлтэй холбоотой зүйлүүдийг манай Санхүүгийн аудитын газрын захирал хариулна. Нөгөө асуудлыг нь санхүү эрхэлсэн, аудит эрхэлсэн орлогч хариулна. Би Оюу толгойн асуудлыг хариулчихъя.

Оюу толгой дээр бид нар аудит хийсэн. Тэгээд энэ Оюу толгой гээд ийм компани байгаа. Тэгээд энд бас ярьж болох, болохгүй ийм сэдвүүд байна л даа. Нэгэнт нууцын дардас дараад нууцын горимоор явуулчихсан учраас. Бид нар бас нэлээн хэдэн зүйл дээр нэлээн шүүмжлэлтэй хандсан байгаа аудитын баг. Тэгээд бас тодорхой хэмжээний хэдэн сая долларын акт, шаардлага тавьсан ч зүйлүүд байгаа. Тэгээд бид нар бас нэлээн бас шахаж л ингэж ажиллая гэж үзэж байна. Тэгээд сая Батжаргал гишүүний ярьж байгаа энийгээ өгөө ч үгүй ийм юу байгаа шүү гэдэгтэй бас санал нэгтэй байгаа. Наранчимэг.

Ц.Даваасүрэн: Гараа өргө, 4 дүгээр микрофон.

Ц.Наранчимэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг.

Төсвийн өсөлт болон энэ төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж байгаа энэ бүтцэд өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит хийхдээ бид энэ талаар бас Сангийн яаманд санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүтцэд өөрчлөлт оруулах ёстой гэсэн ийм зөвлөмжийг хүргүүлж байгаа. Бүтцээ бид энэ төсөвтэйгөө буюу энэ өнөөгийнхөө эдийн засгийн байдалтай уялдуулж одоогийн байгаа төсвийн бүтцийг аудитын байгууллагаас өөрчлөх шаардлага байна гэсэн ийм дүгнэлтийг гаргаж байгаа.

Төрийн хэмнэлтийн тухай хууль гарч хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж бид төрийн байгууллагуудын орон байр ашиглалттай, энэ байр ашиглалттай холбоотой асуудлуудыг аудит болгоноороо үзээд илүүдэлтэй буюу дутуудалтай байгаа байрыг төсвийн, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайландаа тусгаад явж байгаа. Энэ мэдээллийг танд.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Асуугаад байгаа нь энэ төсөв өсөөд байгаа шалтгаан юу байна вэ гээд байна шүү дээ? Юмны үнэ 2 дахин өссөнтэй холбоотой тэр цаас хэрэглэж байгаа юм. Бүх юм түлш, шатахуун, томилолтын зардал энэ бүгд үнийн өсөлттэй холбоотой байна уу, юунаас шалтгаалаад байна вэ танайх шиг орон тоогоо өсгөөд байна уу, яагаад байна вэ гэж асуугаад байна шүү дээ. 4 дүгээр микрофон.

Ц.Наранчимэг: Энэ өсөөд байгаа шалтгаан дээр аудитаар хэд хэдэн зүйлийг бас онцолж байгаа. Нэгдүгээрт нь хөрөнгө оруулалтаар ялангуяа боловсролын салбарт сургууль, цэцэрлэгүүд нэлээн нэмэгдэж байгаатай холбоотой энэ байрны хэмжээний талбай, халаалтын зардал нэмэгдэж байгаа. Үнийн өсөлттэй холбоотой зардлуудын нэмэгдлүүд бол бас байгаа гэдгийг бид тооцоолж гаргаж ирж байгаа.

Ц.Даваасүрэн: Хэдэн хувь нь вэ?

Ц.Наранчимэг: Энэ нэмэгдэл нийтдээ 11-25 хувийн нэмэгдлүүд байна гэдгийг саяын Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар гаргасан. Мөн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгсөн энэ дүгнэлт дээрээ зардал нэмэгдэж байгаа шалтгааныг бид бас хувилж гаргаж хүргүүлсэн байгаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Яг тодорхой та хэд хариулахгүй л байна л даа. Тэр нөгөө хөрөнгө оруулалтын ажлуудын төсөвт өртөгт экспертиз хийгээд танайхаас аудитын дүгнэлт гаргаад байгаа шүү дээ? Энэ хэр бодитой юм бэ гэж асуугаад байна. Тэр хувийн экспертүүд, хөндлөнгийн зөвлөлтүүд ч билүү яагаад байгаа шүү дээ эксперт хийгээд байгаа шүү дээ.

Я.Самбууням: Өмнөх онуудад үүссэн энэ КОВИД-ын дараах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын төсөвт өртгийн нэмэгдлийг бол 2023 онд бол 190 гаран ажил дээр экспертиз магадлалыг нь дахин хийж, төсөвт өртгийнх нь нэмэгдлийг нь хянасан байгаа.

2024 онд бид энэ дээр бол дүгнэлт гараагүй. 2025 он дээр бол энэ ажлууд дээр бас төсөвт өртгийн нэмэгдэл үүсгэх гэж байгаа. Дээр бол аудит хийхээр сэдэв дээрээ оруулчихсан байж байгаа.

Энэ Барилгын хөгжлийн төв болон Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг газруудаас ирж байгаа энэ манайд ирүүлж байгаа санал нь бол.

Ц.Даваасүрэн: Эрчим хүчний зохицуулах хороо биш Эрчим хүчний хөгжлийн төв байх.

Я.Самбууням: Тийм, Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төвөөс манайд ирүүлж байгаа энэ саналууд нь үндэслэлтэй эсэхийг нь бид бас давхар магадалж байгаа. Тэгээд энэ дээр бол бид мэргэжлийн шинжээч.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Тэгээд магадлаад хэр бодитой юм бэ гэж Батжаргал гишүүн асуугаад байна шүү дээ. Бодитой байсан уу, та нарын тэр баталгаажуулж өгөөд байгаа юм гэж? 6 дугаар микрофон.

Я.Самбууням: Энэ дээр бид дүгнэлт дээр бол зарим ирүүлж байгаа дүнгүүд бол хэт өндрөөр нэмэгдлүүдийг тусгасан асуудал дээр нь танаж, бууруулж саналуудыг ирүүлж, Сангийн яаманд хүргүүлж байгаа. Тэгэхээр зэрэг бас үндэслэлтэй төлөвлөгдөхгүй байна, төсөвлөгдөхгүй байна гэж үзсэн.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний 1 минутыг нэмье өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр ерөнхий яриад боломгүй болчхож байна л даа. Энэ зураг төсөв боловсруулдаг тэр заавар, дүрэм, стандарт, аргачлал энэ юмнуудаа бүгдийг нь барьж үзээд зохистой болгох тал руу нь хэдүүлээ анхаармаар байгаа юм. Одоо ганцхан жишээ хэлэхэд 640 хүүхдийн сургуулийг зарим газар 8.5 тэрбумаар барьж байхад, зарим газар дийлэнхдээ 15 тэрбумаар барьж байгаа байхгүй юу. Үгүй тэгээд энийг чинь юу гэж ойлгох юм? Ийм зөрүүтэй төсвүүд зөндөө байна. Та хэд үзээд хэт өсөлттэйг нь бууруулаад Сангийн Яаманд өгч байна гэж байна. Үгүй ээ, яаж өгөөд байгаа юм бэ? Тэр боловсруулдаг аргачлал, заавар, журам нь ижил л байгаа шүү дээ. Тэгээд яагаад тийм зөрүүтэй юмнууд гарч ирээд та хэд тийм саналууд хүргүүлдэг юм?

Тэгэхээр ерөөсөө энэ асуудлуудаа хэдүүлээ цэгцэлж авахгүйгээр энэ төсвийн зардлын тэлэлтийн тухай ярих ямар ч боломжгүй.

Ц.Даваасүрэн: 4, та хэд тодорхой хариул. Яагаад зарим сургууль нь өөр, сургуулийн хүчин чадал нь ижилхэн юм байна шүү дээ. 320, 640 гэдэг ч юм уу тээ? Тэгсэн мөртөө төсөв нь яагаад өөр байгаа юм гэж. Яах вэ тэр газар зүйн байршлаасаа жоохон өөр юм бий. Гэхдээ тэгж 2 дахин болох ёсгүй шүү дээ. Тэрэнд тайлбар өгье. 4.

Ц.Наранчимэг: Энэ барилгын барьж байгаа энэ зураг төсөв, ТЭЗҮ, норм, журмуудаа өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна гээд Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Барилга, хот байгуулалтын сайдад энэ онд багтааж энэ дүрэм, журмаа өөрчлөх асуудлаар аудитын байгууллагаас зөвлөмж өгсөн байгаа. Маш тодорхой зөвлөмжийг өгсөн. Энийг бас Батжаргал гишүүнд хүргүүлье гэж бодож байна. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр байж байгаа. Энэ бол үнэхээр одоогийн мөрдөж байгаа энэ дүрэм, журмууд шаардлага хангахгүй байна гэдгийг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хөрөнгө оруулалтын аудитаар нотлоод энэ талаар зөвлөмжийг хүргүүлсэн. Зөвлөмжийнхөө биелэлтийг энэ 12 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр ийм зөвлөмжийг хүргүүлсэн байгаа.

Ц.Даваасүрэн: Ер нь ийм л юм байна лээ Батжаргал гишүүн ээ. Манайх ингээд яг тогтсон норм норматив гэж юм баталдаг байсныг сүүлийн жилүүдэд ер нь хийхээ больчихсон байгаа байхгүй юу. Техникийн шаардлага гэж юмыг боловсруулах ёстой. Сая жишээлбэл тэр хийн машин дэлбэрлээ шүү дээ. Тэр яагаад дэлбэрч байна гэвэл тэрний техникийн шаардлага, тэрний аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулж чадахгүй байгаа байхгүй юу. Хэдэн минутын дараа дэлбэрэх юм, хэр хүчтэй дэлбэрэх юм гэдэг юмыг хүртэл хийж чадахгүй.

Тийм учраас нөгөө тогтсон норм норматив байхгүй байгаа учраас янз бүрийн хүчин чадлаа нэг ижил хүчин чадалтай ч гэлээ гэсэн доторх материалуудыг нь өөрөөр ч юм уу хийчхэж байгаа байхгүй юу. Хуйвалдаан зөндөө явж байгаа. Тийм учраас ингээд хувийн байгууллагуудаар ингээд зураг төсөв хийгээд байгаа чинь зөв байна уу, үгүй юү? Хувийн эксперт томилоод энэ магадлаад байгаа чинь зөв байна уу, үгүй юү гээд. Ингээд хуулиар шийдэх юм бол зөндөө байгаа юм байна лээ. Энэ барилгын төсвийн асуудал дээр. Нэг ангийн хоёрын нэг нь төсөвчин, зурагчин, нэг нь барилгын компанийн захирал байж байгаа юмнууд зөндөө л байж байгаа шүү дээ. Тийм учраас энэ асуудлуудыг хуулийн дагуу зохицуулах шаардлагатай гэдэг бол яг үнэн зүйл.

Тийм учраас Барилгын хуулийг боловсруулаад бэлэн болчихсон байгаа. Тэгээд Засгийн газраас оруулж ирэх байх гэж би найдаж байна.

Батжаргал гишүүн нэмэлт асуух юм уу, үгүй юү? Дутуу хариулбал 1 минут нэмдэг юм. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тийм юм яахаар та хэд маань нэгдсэн дүн хүргүүлье л гээд байна. Авъя даа. Авахаас яах вэ. Ингээд хэдүүлээ яриад тал талдаа суугаад баймгүй байна. Тэгэхээр зэрэг би энэ аудитын төлөвлөгөө дотор нь тодорхой юмнууд оруулмаар байна. Саяын яриад байгаа юмнуудыг. Тэгж байж тэр Барилгын яамыг нь ч татаж ирье, Сангийн яамыг нь ч татаж ирье, Эдийн засгийн яамыг нь ч татаж ирье, энэ мэргэжлийн байгууллагуудынхаа санал бодлыг ч сонсьё. Тэгээд энэ улсын хэмжээнд нэг мөр ойлгогдож, нэг мөр хэрэгжүүлдэг алагчлалгүй тийм эрх зүйн орчинтой, заавар, дүрэм, стандарттай болж аваад цаашаагаа явмаар байна.

Тэгэхгүй бол энэ баялаг бүтээгчдийн төлж байгаа татварыг бид хэд хаа хаанаа мэдэн будилаад ингээд үрэлгэн байдалтай үрээд, 1 удаагийн маягтай ийм юм хийгээд яваад байдгаа болимоор байна. Энэ нь үнэхээрийн энэ жилийн энэ төсөв бол би муу зүйл болсон гэхээсээ илүү их сайн зүйл болно.

Ц.Даваасүрэн: Ер нь яг нэг жишиг зураг төсөв л гаргах хэрэгтэй. Тэрнээс биш 320-ийн сургууль гэсэн мөртөө маш олон төрлийн зураг, төсөв хийчхэж байна шүү дээ. Тэгээд тэрний нөгөө орц, материал юм нь шал өөр? Тэгээд өөр өөр дүн гараад байгаа энэ тэрийг Батжаргал гишүүний хэлж байгаа шиг бид нар ерөөсөө ингээд тэр норм норматив, стандарт, техникийн шаардлагыг нэг болгоод, 320 хүүхдийн сургуулийг ингэж барина шүү, 640 ингэж барина шүү, үгүй ингэж байж хянахгүй бол ингээд замбараагүй ямар ч зургаар хийж байдгаар бас болохгүй. Тэгэхээр энэ асуудал дээр Байнгын хорооноос бас энэ аудитын юу руу бид нар анхаарч байгаад бас тодорхой асуудлуудыг оруулъя.

Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Баярлалаа. Саяын яг ярьж байгаа сэдэв дээр зүгээр жижигхэн санал бас хэлчихье. Ер нь яах вэ яг энэ олон улсын мэргэжлийн байгууллагууд гээд барилга, зам, эрчим хүч, энэ төсөв, санхүү, стандартуудтай холбоотой байнга тасралтгүй шинэчлээд явж байдаг. Тэгээд зөвхөн ерөөсөө энэ норм норматив тухайн орны цаг уур амьсгал, газар нутагт таарсан материалын судалгаа төсөв зургийг нь сайжруулаад тэгээд хамгийн хямд өртгөөр байлгах тэрийг нь мэргэжлийн түвшинд хийгээд тэр хүрээнийх нь норм нормативынх нь дагуу зураг төслийн байгууллагууд нь бас ажиллаад явж байдаг учраас энэ мэргэжлийн байгууллагуудаа яамнууд хөгжүүлэх шаардлагатай юм болов уу гэсэн нэг ийм санал байна.

Дээрээс нь энэ аудитын сэдвээс асуухад энэ үнэ тогтворжуулах зорилгоос төрөөс олгож байгаа татаас, нөхөн олговрын зарцуулалтын талаар ойрын үед ер нь аудит хийсэн үү? Би энэ дээр аудит хийсэн бол ямархуу дүн байгаа вэ? Хамгийн сүүлд хэзээ хийсэн бэ?

Хоёрдугаарт, нефть боловсруулах үйлдвэрийн үйл явц, зээлийн зарцуулалт гэж яригдаж байгаа.

Гуравдугаарт хамгийн сүүлийн үеийн бас халуун сэдвүүдийн нэг болоод байгаа энэ төрөөс эрчим хүчний салбарт баримталж байгаа бодлого, үнэ тарифын зохицуулалт, үүний өртөг, зардлын талаар ер нь аудит хийсэн үү? Тэгээд энэ 3 сэдвүүдийн талаар хамгийн сүүлд хэзээ аудит хийв, ямархуу дүгнэлттэй байв? Одоо энэ сэдэв дээр нэмж оруулах санал оруулах гээд байгаа учраас энэ тал дээр надад тодорхой мэдээлэл өгөөч гэж хүсэх гэсэн юм.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүний асуултад 6 номерын микрофон хариулъя.

Я.Самбууням: Үндэсний аудитын газар Самбууням байна. Түвшин гишүүний асуултад хариулъя. Түвшин гишүүний саяын асуусан энэ эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, тэгээд энэ үнэ тогтворжуулалтын улсын төсвөөс нөхөн олгож байгаа нөхөн төлбөр эдгээр аудитыг бол сүүлийн жилүүдэд хийгээгүй. Хамгийн сүүлд эрчим хүчний салбарын үнэ, тарифын зохицуулалтыг бол 2020 онд, 22 онд хийж гүйцэтгэсэн. 20 онд, 22 онд хийж гүйцэтгэхдээ бол 19-21 оныг хамруулсан байж байгаа.

Үнэ тогтворжуулалтын асуудлыг бол Монголбанк дээр бол бид бас 21 онд хийсэн байгаа. 21 онд хийхдээ бол 18-20 оныг хамруулж хийсэн байгаа. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Нэмж асуух юм уу, аль эсвэл зүгээр зарчмын зөрүүтэй санал хураалгачих юм уу? Тэгвэл Түвшин гишүүн зарчмын зөрүүтэй санал болгоод хураалгачихъя.

Аубакир гишүүн асуултаа асууж, үг хэлье.

Т.Аубакир: Баярлалаа. Аудитын ирэх жил хийгдэх сэдвүүдтэй танилцлаа. Энэ дээр зөв, зүйтэй бас шалгалт хийх, аудит дүгнэлт гаргах ийм зайлшгүй шаардлагатай зүйлүүд орсон. Би энэ дээр хэлэх гэж байсан зүйл энэ төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд зайлшгүй аудит хийх шаардлагатай байж байгаа. Энэ төрийн өмчит болон орон нутгийн өмчтэй компаниудын удирдлагыг сайжруулах, менежментийг нь сайжруулах зайлшгүй ийм

шаардлага тулгарч байгаа юм. Үнэхээрийн ашиггүй, алдагдалтай ажиллаж байгаа зарим ТӨК-удыг хувьчлах, олон нийтийн болгох чиглэлээр ажиллаж байгаа бас ажлын хэсэг байгаа. Ер нь цаашдаа төрд ийм олон ТӨК байгаад байх шаардлага байгаа юм уу, үгүй юм уу? Энийг мэдээж хэрэг танай энэ хийх дүгнэлт дээр үндэслээд шийдэх байх.

Гэхдээ энэ хугацааны хувьд 2 сарын 15-аас 3 сарын 15-ны дотор 1 сарын дотор чухам багтаж байна уу үгүй юу хийж? Энэ дээр зарчмын зөрүүтэй санал байх ёстой юу, эсвэл энэ сэдэв дээрээ нэмж өгөөч гэх юм уу яах юм? Энэ Хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд зайлшгүй хяналт, дүгнэлт хийх шаардлага бий болчихсон юм. 22 оны 4 сарын 29-ний өдөр батлагдсан хууль түүнээс хойш 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ Хэмнэлтийн хуулийг 22 онд баталснаар энэ Монгол Улсад энэ төсвөөс ер нь хэдий хэмжээний хэмнэлт бий болж чадсан юм? Яг энэ хууль маань яг хэрэгжсэн юм уу, үгүй юм уу? Ингээд ажиглаад байх нь газар, хэлтсийн дарга нар байдаг ч юм уу, зарим албан хаагч нарын унаж байсан унаа тэргийг бүгдийг нь Улаанбаатар хотод төвлөрүүлээд, аймаг дээр нь төвлөрүүлээд л байсан. Баахан эвдэрхий, хэмхэрхий машин л авчирсан. Үүнийхээ дараа нөгөө машинаа өгчихсөн дарга нар чинь дахиад л шинэ тэрэг уначихсан л явж л байгаа л даа. Энэ чинь яг бодитой хэмнэлт энэ хуулийн хүрээнд гарч чадсан юм уу, үгүй юм уу. Яг ний нуугүй хэлэхэд.

Ер нь энэ Хэмнэлтийн хууль цаашдаа ер нь байх хэрэгтэй юм уу, үгүй юм уу, яах вэ? Энэ КОВИД-той холбоотой тухайн үед цаг үеэ олсон л ийм шийдвэр байсан 22 онд. Одоо энэ хэмнэлт хийх бол энэ хууль болгон дээр газар хэлтсийн, агентлагуудын байдаг ч юм уу яамнуудын бүхий л эрх зүйн бичиг баримт дээр байж байгаа шүү дээ. Төсөвт хэмнэлттэй хандах, оновчтой зохион байгуулах гэдэг ч юм уу. Одоо энэ хажуугаар нь Монголд хэрэгжиж байгаа хуулийн тоо нэмэх гэж байгаа юм шиг бас дэмий хууль байгаад байгаа юм шиг надад санагдаад байгаа.

Тийм учраас миний хэлэх гэж байгаа санал бол ирэх жилийнхээ хийх, энэ дүгнэлт гаргах энэ сэдвүүд дээрээ Хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавиад яг одоо нийцэж байгаа юм уу, үгүй юм уу? Танайд нийцлийн аудит гэж байж байгаа. Энэ гаргасан хууль маань яг одоо манай энэ бидний хүсээд байгаа тэр хэмнэх гээд байгаа зүйл энэ төсвийн хэмнэлт дээр яг нийцэж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг нийцлийн дүгнэлтийг гаргах зайлшгүй шаардлагатай байгаа.

Тийм учраас Даваасүрэн дарга энэ санал дээр, сэдэв дээр нь оруулаад явах юм уу, эсвэл зарчмын зөрүүтэй санал гаргах уу? Бид нар энэ Хэмнэлтийнхээ тухай хууль дээр аудит хийх зайлшгүй шаардлага бий болчихсон байж байгаа. Өчигдрөөс эхлээд яриад ирлээ. Энэ хуулиа цааш нь баяжуулаад явна гэж байгаа юм. Үгүй, баяжуулах гэж байгаа юм бол бид нар энэ өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилтийн хүрээнд тэнд тэрбум төгрөгийг бид нар хэмнэж чаджээ. Тэнд данхайчихсан байсан төрийн албыг бид нар цомхотгож чаджээ.

Тийм учраас энэ Хэмнэлтийн хууль байх ёстой юм. Үгүй бол, огт энэ хууль ерөөсөө хэрэгжилтээ үүргээ гүйцэтгээгүй юм. Тийм учраас энэ хуулийг байхгүй болгох ёстой юм уу? Энэ хуулийн хүрээнд ний нуугүй хэлэхэд энэ зуд зурхан болдог, хөдөө гадаа давхидаг хэдэн албан хаагч нарын унаа тэрэг, мотоциклийг л хурааж авсан шүү дээ. Яг л ажил хийдэг хүмүүсийн. Одоо энэ хөдөө орон нутгийн удирдлагууд хийж байсан гишүүд бас сууж байгаа. Энэ хууль чухам хэрэгтэй юм уу, үгүй юм уу? Тэр том аймгийг удирдахад аймгийн Засаг дарга чинь ганцхан

орлогчдоо, яг иргэддээ хүрч ажиллаж чадаж байгаа юм уу? Сумын орлогч нь нохой буудах хүртэл ажил хийгээд л явж байдаг шүү дээ.

Гэтэл аймгууд дээр орлогчийн тоог нэмэх зайлшгүй шаардлага бий болж байна. Тийм учраас миний хэлэх гэж байгаа санал бол энэ Хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дээр нийцлийн аудит хийгээд дүгнэлт гаргаж өгөөч гэсэн ийм саналтай байгаа юм. Энэ сэдэв дээр оруулах ёстой юу, яах ёстой юм дарга? Тэр шийдвэр гаргаж өгнө үү гэж.

Ц.Даваасүрэн: Аубакир гишүүний хэлсэн тэр эхний ТӨК-удын үйл ажиллагаатай бол шалгалтын асуудлаар Батбаяр гишүүн санал гаргаад оруулаад явж байгаа. Хэмнэлтийн хуулийн асуудлыг та санал гаргаад оруулж болно. Ер нь төрийн өмчийн компаниудын хувьд бас ийм юм яваад байх шиг байна. Хувьчилж авах гэдэг далд санаа байдаг. Мэдээж улс орноо тэжээж байгаа энэ том аж ахуйн нэгжүүдийг авъя гэдэг бодол байгаа шүү дээ энэ нэг хэсэг. Авчихсан хойноо яах вэ хувийн болоод л явна.

Гэтэл КОВИД хүнд цаг үед хэн тусалсан, хэн эрчим хүчний иргэдийн тэр хүндрэлтэй мөнгийг төлсөн? Улаанбаатар хотын түлшний зөрүүг хэн төлсөн? Нөгөө төрийн өмчийн компаниуд шүү дээ. Ялангуяа энэ жижиг зах зээлтэй орнууд хараад байхад. Норвег, Дани, Чили энэ тэр бол Финлянд байна. Стратегийн компаниуд нь дандаа төрийн өмчийн юм байгаа шүү дээ. Ард түмнээ тэжээх гэж. Зүгээр компанийн удирдлагыг нь сайжруулах асуудал. Тэрнээс биш муу хэлсээр байгаад 1, 2 гэр бүлд очно гэдэг тийм сайн зүйл биш үү, үгүй юү? Ер нь бид нар ухаарах цаг болсон шүү.

Тэгэхдээ бид нар харин үйл ажиллагааг нь сайн байлгахын тулд хяналт тавих нь зөв. Тийм учраас Далайн Батбаяр гишүүн энэ санал гаргаад энэ тусаад явж байгаа.

Тэр Хэмнэлтийн хуулийн үр дүн хэрэгжилттэй холбогдолтойд шаардлагатай гэж үзвэл зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаад хураалгаж болно.

Дамдинням гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Дамдинням: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Аудитын байгууллага манай Улсын Их Хурлын парламентын шийдвэр гаргахад нүд, чих болж, тулах цэг болдог байгууллага. Тэгээд яах вэ, Аудитын байгууллагаас хэдэн асуулт байгаа юм. Энэ сэдэв нэгэнт орж ирж байгаа учраас.

Нэгдүгээрт, энэ Төрийн сангуудын мөнгийг ярих хэрэгтэй байгаад байгаа юм. Түрүүн Ганхуяг гишүүн хэллээ. Үүн дээр ялангуяа энэ Хөдөө аж ахуйн яам гэж халамжийн яам байна. Том том нэртэй хөтөлбөрүүд орж ирж байна, том том нэртэй хөтөлбөрүүд нь төсөв дээр багц дүнгээрээ орж ирж байна. Орж ирсэн тэр төсвүүд нь яаж зарцуулагдаж байгаа тухай ер нь аудит ер нь та нар хийсэн юм байдаг уу? Сайд нь л өөрийнхөө эргэн тойрны хүмүүст тараагаад сууж байдаг ийм сангууд байгаад байгаа л харагдаад байгаа юм даа. Энэ дээр ер нь та нар аудит хийсэн үү? Хийгээгүй бол даргаа энийг ер нь энэ аудитын жагсаалтад оруулмаар байна, сэдэвт оруулмаар байна. Энэ Хөдөө аж ахуйн яамны тусгай сангуудыг нь оруулж аудит хиймээр байгаа юм. Яг хэнд хэдийг өгчхөөд байгаа юм? Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн тал мөнгөнөөс илүүг нь ганцхан компани хамаарал

бүхий этгээдүүдээрээ цуглуулчихсан тухай асуудал яригдаж л байсан шүү дээ. Тэгэхээр энэ асуудлуудыг хэдүүлээ бас ярих ёстой.

Хоёрдугаар асуудал энэ төрийн мөнгө, өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн мөнгө, НДШ төлөгчдийн мөнгө, ЭМД шимтгэл төлөгчдийн мөнгө орсон энэ арилжааны банкнууд руу орсон үйл явцыг бас аудит хийчихмээр байгаад байна. Би энэ мэдээллийг нэлээн цуглуулаад л яваад байна. “Чингис Хаан” банкнаас хэрэв энэ сангуудаас зөвхөн Нийгмийн даатгалын сантай холбоотой 95.3 тэрбум төгрөгийн авлагатай авч чадахгүй ингээд явж байна.

“Капитал” банк дампуурчихсан банкнаас 65.9 тэрбум төгрөгийн ард иргэдийн тэтгэврийн мөнгө, ЭМД-ын төлбөр эрсдэлд орчихсон явж байна. Цаана нь уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн мөнгө байгаа, Эрдэнэс Тавантолгойн мөнгө байгаа. Хадгаламжийн даатгалын корпорацийн мөнгө байгаа, төрийн өмчит Монголын цахилгаан холбоо гээд ингээд бүх ТӨК-удаас орчихсон мөнгөнүүд байж байгаа байхгүй юу энэ арилжааны банкнууд дээр.

Би Монголбанкны Ерөнхийлөгчөөс энэ зохистой харилцааны мэдээллийг нь ингээд он оноор нь ингээд аваад цуглуулаад ингээд байж байна. Үйл ажиллагаа нь доголчихсон байхад нь л энэ сангуудаас шийдвэр гараад л мөнгө хийгээд байсан байгаа байхгүй юу. Мөнгө хийгээд байсан байгаа юм. Хэдэн 10 тэрбумаар нь. Энэ дээр ер нь аудит хийсэн байдаг юм уу? Байгууллага байгууллагаар нь аудит хийгээд л нэг нэгээр нь ярихаар энэ чинь жижиг юм харагдаад яваад байгаа байхгүй юу.

Гэтэл яг энэ хүндэрчихсэн байгаа энэ 3 банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банк, Капитал банк гээд яг энэ зохистой үйл ажиллагааны харилцаа нь алдагдчихсан байгаа банкнууд руу төрийн сангийн мөнгөнүүд, төрийн өмчит болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мөнгөнүүд ороод эрсдэлд орчихсон байгаа тухай асуудлыг аудит ер нь шалгасан уу? Хэрвээ шалгаагүй бол энийг аудитын энэ сэдэвт оруулж бас бид нар ярих хэрэгтэй байна дарга. Хэдүүлээ энийг бас би энэ дээр зарчмын зөрүүтэй санал гарч энэ асуудлыг яримаар байна. Тэгээд энэ дээр хариулт өгөөч. Энэ 2 асуултад тэгээд тодруулъя.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүний асуултад хариулъя. 5 номерын микрофон.

Д.Загджав: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Маш зүйтэй асуудлыг хөндөж байгаа юм. Ер нь бол тусгай сангуудаас гадна, Төрийн сангийн гүйлгээ ямар нэгэн тийм аудитгүй яваад байгаа юм. Тэгэхлээр энэ бүгдийг бас, бүгдийг нь энэ бас аудит хийдэг болохгүй бас яриа хөөрөө гараад байгаа.

Тухайлбал, миний хамгийн сайн мэддэг ОХУ-д бол төрийн сангийн хяналтын алба гэж тусдаа байдаг. Тэгээд энэ аудит дотроо ингээд хянаад явж байдаг юм. Тэгээд манайх бол тийм юм байхгүй л юм байна лээ. Цаашдаа энэ сэдэвт оруулаад ингээд Төсвийн байнгын хороо шийдээд өгвөл бид бүхэн бас энэ дээр аудит хийгээд ингээд явах ёстой байх. Тэгээд энэ тусгай сангууд дээр сүүлийн үед аудит хийгээгүй юм байна лээ.

Ц.Даваасүрэн: Тусгай сангууд дээр хэрвээ аудит хийх шаардлагатай гэвэл зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгаж болно шүү дээ. Хийж байсан юм, хийж байсан юм. Тийм, хийж байсан юм.

Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Тэгэхээр энэ төрийн энэ тусгай сангууд тухайн нэг салбар дээр би түрүүн тодорхой хэллээ шүү дээ Хөдөө аж ахуйн яаман дээр ч гэдэг юм уу, эсвэл аль ч яаман дээр байдаг юм, хамаатай энэ сангууд тухайн сайдын эрх мэдлээ хадгалах, эргэн тойрныхоо хамаарал бүхий этгээдүүдээ угжих, тэтгэх, өөрийнхөө бизнесийг дэмжих ийм хэрэгсэл болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг та бүхэн нэгдүгээрт энэ салбар, нэгж сан болгоноор нь ялгаад ингээд аудит хийхдээ зэрэг том юм харагдахгүй байгаад байгаа юм. Нийт том дүнгээр нь яг тэр яамнаас гарч байгаа бүхий л сангуудыг нэг гаргаж ирээд том дүнгээр нь харвал наадах чинь аймшигтай юм харагдана шүү дээ. Би түрүүн хэлж байна шүү дээ. Нэг гэр бүл, нэг бизнесмен олон өөр охин компани, хамаарал бүхий этгээдүүдээрээ байгуулж байгаад л бүх санг нь авчихсан юмнууд харагдаад байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ төрийн сангууд орсон байгаа мөнгөнүүд дээр нь.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Засгийн газрын тусгай зориулалтын санд хамгийн сүүлд хэзээ аудит хийсэн бэ гэж байна. Хариулах уу? 4.

Ц.Наранчимэг: Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тухай хуулийн 8.9.9-нд заасны дагуу Засгийн газрын тусгай санд төсвийн хуулийн цаглаварт хугацаанд аудитыг хийж гүйцэтгэж дүгнэлт гаргаж байгаа. Монгол Улсын Ерөнхий аудитор дүгнэлтээ баталгаажуулаад ингээд холбогдох байгууллагуудад нь хүргэж байгаа.

Хөдөө аж ахуйн яаман дээр Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан татан буугдаад корпорац болсон байгаа. Энэ дээр бид бас санхүүгийн тайлангийн аудитыг жил бүр хийж байгаа. Тариалан эрхлэлтийг, корпорац дээр аудитаар сөрөг дүгнэлтийг өгсөн. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан дээр хязгаарлалттай санал, дүгнэлтийг жил болгон өгч байгаа.

Энэ дээр эрсдэл байгаа гэвэл л байгаа. Энийг бол тухайн тайлангууд дээр нь сайд нь болон холбогдох хүмүүст нь дүгнэлтээ гаргаад, зөвлөмжөө өгөөд явж байгаа.

Ц.Даваасүрэн: Дамдинням гишүүн ээ та хэрвээ зарчмын зөрүүтэй санал гаргаад хураалгавал боломжтой шүү.

Батлут гишүүн асуултаа асууж үг хэлье.

Бид нарыг нөгөө чуулганы хуралдаан руу бас дуудаад байна.

Д.Батлут: Өглөөний мэнд хүргэе.

2025 оны төсөв хэлэлцэж байгаа цаг хугацаанд 2025 оны аудитын сэдэв батлах асуудал Байнгын хорооны хурлаар орж ирж байна. Бас энэ төсөвтэй холбоотой асуудлууд үүсээд нэлээн алдагдалгүй төсөв батлах, тэгээд хөрөнгө оруулалт, бусад асуудлуудаа бас шингээх гээд л их л асуудалтай явж байгаа юм. Тэгээд би энэ төсвийн эрүүлжүүлэх процессыг хэрхэн хийх вэ гэдэг дээр нэлээн анхаармаар байна гэж яриад байгаа юм л даа. Тухайлах юм бол 23 онд Эдийн засгийн байнгын хороогоор асуудал яригдаж байсан. 22 оны төсөл, хөтөлбөр арга хэмжээ 400 орчим арга хэмжээнд, 200 орчим арга хэмжээнд нийцлийн аудит хийхэд 80 орчим тэрбум төгрөгийн хий тооцсон тооцоолол гарсан байна гэж дүгнэгдэж байсан. Тэгвэл энэнтэй холбоотой ямар арга хэмжээ авсан юм аудитын байгууллага?

Хоёрдугаарт нь 23 он дээр нийцлийн аудит хийсэн үү төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүд дээр? Энэ дээр ямар үр дүн гарав? Бид ингээд түрүүн Батжаргал гишүүн ч гэсэн яриад байна лээ л дээ. Ингээд харилцан адилгүй өндөр дүнтэй хөрөнгө оруулалтууд яваад байна. Нэг ижил сургууль гэхэд нэг газар 8 тэрбумаар босож байхад нөгөө газар арван гурав, дөрөв, таван тэрбумаар босоод байна. Энэ Барилгын хөгжлийн төв дээр асуудал байна, энэ мэргэжсэн инженерүүд дээр асуудал байна гээд байгааг л яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүн дээр энийг асуудлыг цэгцлэхийн тулд аудитын байгууллагын нийцлийн аудит хийгээд яг тэр зөрчил дутагдлыг илрүүлж гаргаж ирсэн тэр асуудлууд байвал энэ тал дээрээ 22 онд ийм, 23 онд ийм гэсэн хариултыг надад өгөөч. Үүн рүү чиглэсэн ямар арга хэмжээ авах гэж байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь би асуулт дуусаагүй байна. Оюу толгойн төслийн Монголд тийм үр өгөөжгүй төсөл байна гэдэгтэй би санал нэг байгаа. Түрүүн Батжаргал гишүүн бас хэлчихлээ. Би ганцхан жишээ л хэлмээр байна. Одоо ингээд төсөв хүрэлцэхгүй байгаа асуудлууд дээр асуудлууд үүсээд байна шүү дээ. Төсвийн мөнгө хүрэлцэхгүй, хөтөлбөр, арга хэмжээнүүд багтахгүй байна. Алдагдалгүй төсөл батлах гээд байна гээд. Оюу толгой төсөв төсөл 2010-2022 он хүртэл АМНАТ төлөхдөө, зөвхөн АМНАТ төлөхдөө 372 сая доллар л төлсөн байна. Монгол Улсад АМНАТ-ын татвар шүү. 12 жилийн хугацаанд тогтворжуулалтын гэрээтэй.

Тэгсэн Эрдэнэт үйлдвэр зөвхөн энэ оны 9 сарын 30-ны байдлаар 615.2 тэрбум төгрөг буюу 180 сая доллар төлчихсөн байгаа. 20 хувиар тооцож АМНАТ төлсөн байна. Монгол Улс нэгдсэн тийм хуультай байхгүй юу. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт чинь яагаад төрийн өмчийн компани дээр өөр, хувийн, гаднын хөрөнгө оруулалттай компани дээр өөр яваад байгаа юм бэ? Энийг яаж алга болгох юм? Үгүй ингээд муу, номхон тэмээ ноолоход амар гэххээд энэ төрийн өмчийн компаниуд чинь сөхөрлөө шүү дээ. Тэнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын цалин хөлс, уул уурхайн ижил, уул уурхайн компаниудын ижил түвшинд очих хэрэгтэй байна шүү дээ. Тэр мөнгөөр цалинг нэмэх хэрэг байна шүү дээ. Техник, технологийн шинэчлэлүүдийг хийх хэрэг шаардлага байна шүү дээ. Яагаад энэ дээр аудитын байгууллага ингээд дүгнэлт гаргахгүй байгаа юм бэ? Ер нь шалгаж үзсэн зүйл байдаг юм уу? Ингээд 2 ижил компани байдаг. Нэг нь гаднын хөрөнгө оруулалттай, нэг нь төрийн өмчийн хөрөн компани байдаг.

Гэтэл АМНАТ нь ийм ижил, тэгш бус байдлаар бий болж, тавьж байгаагаас шалтгаалаад Эрдэнэт үйлдвэрийн цаашлаад Эрдэнэт үйлдвэрт ажиллаж байгаа

баялаг бүтээгчдийн эрх ашиг ноцтой зөрчигдөж байна нөхөд өө. Энэ дээр хариулт өгөөч гэж хүсье. Тодруулъя дараа нь.

Ц.Даваасүрэн: 2 асуулт асуусан байна шүү. Тэр аудитын юун дээр нь бол би тэр нууцаар ирүүлсэн байгааг нь ер нь гишүүдэд тааръя. Ер нь бас манай гишүүд бас тэрийг сайн үзэх хэрэгтэй. Ер нь Оюу толгой чинь 40 гаруй сая тонны зэс, 1800 тонн алт, одоо алтны үнэ хоёр мянга дөрөв, таван зуу байна шүү дээ. Ингээд бодохоор зөвхөн алт нь 130 гаруй тэрбум доллар байдаг байхгүй юу. Зөвхөн алт нь. Нөгөө зэс нь гэхэд мөн хоёр, гурван зуун тэрбум доллар. Ингээд нийтдээ ингээд 400 тэрбум долларын орд байгаа мөртөө энэ 50 жилийн хугацаанд Монголд 10-хан тэрбум доллар төлнө гээд бод доо та нар. 10-хан тэрбум доллар. 400 тэрбумаас 10-хан тэрбум доллар төлнө гээд бод л доо. Тэгэхээр та нар энэ том луйварт оролцоогүй учраас бол харин хамгаалахгүй ингээд ярьдаг болсон байна. Маш сайн. Хуучин бол дандаа оролцчихсон улсууд байдаг байсан учраас энийг ярихаас залхдаг, ярьсан хүнийг шахдаг тийм байсан юм.

Тэр аудитын дүгнэлтийг би тараана. Аудитаас бусдыг нь аудиттай холбогдлоо ч гэсэн та бүхэн хариулчих. 2 асуулт байна. 4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Батлут гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолоор төсөвт өртгийн нэмэгдлийн аудитыг 1 удаа хийсэн. Энэ тогтоол маань өөрөө тухайн 2023 ондоо хэрэгжих ийм тогтоол байсан. Үүгээр 88.9 тэрбум төгрөгийг аудит хийж, хөрөнгө оруулалтад аудит хийж хасагдах зардал байна, буруу төлөвлөсөн байна гэж тооцсон. Жил бүрийн төсвийн гүйцэтгэлд хийж байгаа хөрөнгө оруулалтын аудит дээр мөн энэ бас энэ барилга байгууламжийн зураг төсөлтэй холбоотой анхаарах асуудлууд байгаад байгаа.

Тийм учраас Барилга, хот байгуулалтын яаманд барилгын байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэл илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгарч байгаа асуудалд судалгаа, шинжилгээ хийж барилгын норм норматив дүрэмд, дүрмээ шинэчлэх гэсэн ийм зөвлөмжийг хүргүүлсэн байгаа. Дахиж төсөвт өртгийн нэмэгдлийн гүйцэтгэлийн аудит хийгээгүй. Одоо энэ сэдэв батлагдах юм байна гэж ингэж бид нар ойлгож байгаа. Энэ сэдвээр төсөвт өртгийн нэмэгдлийн аудитыг хийлгэхээр орж ирэх юм байна гэж.

Манай төрийн аудитын байгууллага дандаа төрийн байгууллагуудад аудит хийдэг. Гадаадын хөрөнгө оруулалттай компанид аудит хийдэггүй байгаа.

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн. Чуулган санал хураах гээд.

Д.Батлут: Яах вэ ингээд хариултыг авч байна л даа. Бид нар энэ байдлаар ингээд 23 он дээр Улсын Их Хурлын 88 дугаар тогтоолоор 1 удаа аудит хийхэд 88 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Хийдэл. Тэгээд бид нар энийг өөрчлөх боломжтой шүү дээ. Та бүхэн санал оруулаач дээ. Тэр зураг төсөв нь гаргаад экспертиз хийгдсэний дараа заавал нийцлийн аудитад орж байгаад хөрөнгө оруулалтад тусгадаг больё л доо тэгвэл. Юмыг хойноос нь явах биш, дандаа дэс дараалалтай явдаг больё. Энэ тал дээр санаачилгатай ажиллаарай.

Хоёрдугаарт нь гаднын хөрөнгө оруулалттай компани гэнэ бас боломжгүй гэх юм. Энийг боломжтой болгох боломжууд бас байдаг байх гэж бодож байгаа.

Өнөөдөр Оюу толгой өнөө 5, хувийн АМНАТ төлж байгаа. 5 хувийн шүү. Тэгэхэд уулын Баяжуулах Эрдэнэт үйлдвэр 20 хувь. Үгүй ийм байж болдог юм уу? Тэгээд 1 жилд уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр зүгээр оны эхний 9 сарын байдлаар л 180 сая доллар төлчихсөн байхад, тэр Оюу толгой төсөл чинь 12 жилд 300.../минут дуусав./

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн санал хэллээ. Энэ дээр юу Оюу толгой чинь төрийн өмчийн оролцоотой 34 хувьтай учраас та бүхэн аудит хийж болно.

Тийм учраас аудит хийчихсэн юм байна лээ. Тэгээд тэр аудитын нууцаар ирүүлчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би та бүгдийг нууцаар танилцуулах боломжийг бүрдүүлж өгье за юу.

Булгантуяа гишүүн асуулт асууж, үг хэлье. Чуулган руу дуудаад байна.

Х.Булгантуяа Би хэд хэдэн юмнуудаас санал хэлэх гэсэн юм.

Нэгдүгээрт иргэдийн зүгээс энэ торгууль, төлбөр орж ирж байгаа байдал түүний царцалтын тухай их асууж байна. Үүнтэй холбоотойгоор торгуулийн төлбөрийн орлого, түүний зарцуулалтын тухай харин яаж томъёолох вэ манай аудитынхан тэр дээр байгаад өгөөч тэгэх үү? Үүнийг бид нар яг иргэд, олон нийтийн зүгээс энийг маш их сонирхож байгаа сэдэв байгаа учраас нэн чухал гэж үзэж байгаа учраас хармаар байна.

Хоёрдугаарт, дахиад дээрээс нь нэмээд эмийн сонсгол явагдсан. Бид нар энэ сонсголудынхаа араас ер нь өөрснөө араас нь үргэлжлүүлэн ач холбогдол өгдөг, нөгөө олон ярьсан үр дүн хаана байна гээд иргэд олон нийтийн зүгээс бухимдаад байгаа. Тэгэхээр энэ Эм, эмийн хэрэгслийн агентлагийн гүйцэтгэлийн аудит хиймээр байна. Эм, эмийн агентлагийн гүйцэтгэлийн аудит. Энэ бараг яам шиг бүтэцтэй, төсөвтэй ийм агентлаг бид нар байгуулсан. Ингээд яг үр дүндээ хүрч байна уу, үгүй юү? Эм, эмийн хэрэгслийн агентлагийн гүйцэтгэлийн аудит.

Хөгжлийн банкны гүйцэтгэлийн аудит бас хиймээр байна. Хөгжлийн банкны сонсгол хийсэн. Хөгжлийн банкны үйл ажиллагаа нь одоо ямархуу явж байгаа юм, сайжирсан юм уу? Тэндээс өгсөн зөвлөмжүүд тэр юмнууд юу болсон юм байгаа юм? Тэрүүнийг сонсмоор байна.

Дээрээс нь 24 онд шинэ 2 багц хууль хэрэгжиж эхэлсэн. Улсын Их Хурлын уг нь хуулиа батлаад ингээд хаячихдаг биш, баталсан хуулийнхаа араас хэрэгжилт дээр нь давхар хяналт тавьдаг байж байж энэ үр дүнгээ өгнө. Боловсролын багц хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн, Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжиж эхэлсэн. Үүн дээр зүгээр яах вэ, бүүр гүн гүнзгий биш юм гэхэд ядаж нэг ерөнхийдөө эхний жил гүйцэтгэлийн аудитын тайлан гарах юм уу тийм байдлаар.

Хэрвээ хууль нь биш байгаад байгаа хуулиа дагасан журмууд нь гараагүй дутуу дулимаг гарсан байгаа бол бид нар үүнийг эртхэн шиг засаад сайжруулаад явах энэ арга хэмжээг бас авах нь зүйтэй байх гэж бодож байна.

Дараачийн юм нь би ер нь энэ Монголбанкны энэ дээр аудит хийсэн гэж ер нь энэ гишүүн байх хугацаанд ерөөсөө сонсоогүй. Танайд ер нь, бодвол энэ чинь улсын төсвөөс цалинжиж байгаа хүмүүс л байгаа тээ? Одоо сүүлийн үед энэ Монголбанкны дарга нар ТӨК-ийн захирлууд энэ тэр гээд зарим хүмүүс чинь

Монголын топ баячууд болчхож гээд л энэ сошиалаар л яваад байх шиг байна. Тэгэхээр энэ Монголбанкны аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороон дээр бас бид нар сонсмоор байна. Улсын Их Хурлаас удирдлага нь сонгогддог, томилогддог ийм албан тушаалтнууд байгаа дээрээс нь нэмээд доор нь ажиллаж байгаа хүмүүс ч гэсэндээ. Би ер нь ерөөсөө Монголбанкны аудит гэж сонсож байгаагүй.

НД, ЭМД-ын сангийн аудитыг та бүхэн угаасаа жил болгон хийж байгаа байх тээ? Нөгөө улсын төсвийн нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байгаа учраас угаасаа хийж байгаа байх. Тэр бол харьцангуй гайгүй байх гэж бодож байна. Харин бас манай Улсын Их Хурлын гишүүдээс яриад байгаа энэ татвар, нийгмийн даатгалын шимтгэл дээр өр, авлага маш их үүсээд байна гэдэг талаарх мэдээллийг бид нар сонсох юм сан. Үүнийг бас яаж томъёолж оруулж өгөх вэ? Та бүхэн хараадхаач.

Яагаад гэвэл одоо иргэдийн зүгээс татвартай холбоотой реформ ч байдаг юм уу хийгдээсэй гэж маш их хүсэж байна. Үүнийг мэргэжлийн байгууллагын аудитын дүгнэлтийг харж байж л бид нар хийхгүй бол үүнийг сэтгэлийн хөөрлөөр хийх юм бол маш их алдаа гарах учраас та бүхэн үүн дээр бид нарт аудитууд хийж, төлөвлөгөөндөө оруулж өгөөч гэдэг ийм хэдэн саналууд байна.

Ц.Даваасүрэн: Ингэе Булгантуяа гишүүн, саяын хийсэн юун дээр манай аудитынхан Булгантуяа гишүүнд хэлээд аудит хийгдээгүй, огт хийгдээгүй юмнууд дээр зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаад ингээд хураалгая.

Чуулган дээр ирц бүрдэхгүй байгаа юм байна. Тийм учраас ирц бүрдүүлээд, санал хураалт хийнэ гэж байна. Тэгэхээр санал хураалтыг хийчхээд буцаж орж ирээд хуралдаанаа үргэлжлүүлэе.

Та бүгдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дээр санал хураалт явуулна. Булгантуяа гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо бэлдээд өгчихье.

Хэдүүлээ чуулган руу орчхоод тэгээд үргэлжлүүлнэ. Энэ бидний энэ ирц үргэлжлээд явна шүү. Байнгын хорооны энийг өөрчлөв.

Хуралдаан 11 цаг 34 минуутаас 11 цаг 41 минутад түр завсарлав.

Ц.Даваасүрэн: Хуралдаанаа үргэлжлүүлэе.

Булгантуяа гишүүн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаа бэлдсэн үү? Одоо Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хураалт явуулъя гишүүд ээ.

6 санал байгаа юм байна. Ингээд санал хураалт явуулъя. Байнгын хорооны гишүүдийн ирц 23 байгаа учраас нэлээн өндөр ирцээр санал хураалт явагдах юм байна. Гишүүд танхимдаа орж ирье. Айн, гишүүд санал хураалт явуулъя.

Аубакир гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд дүгнэлт хийх, аудит хийж, дүгнэлт гаргах гэсэн санал гаргаж байна.

Аубакир гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Бодит амьдрал дээр хэцүү хууль.

23 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 69.6 хувиар уг санал дэмжигдэж жагсаалтад орохоор боллоо.

Дамдинням гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагааны санхүү гүйцэтгэлийн аудит хийх гэсэн санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

23 гишүүн санал хураалтад оролцохоос 13 гишүүн оролцож, 56.5 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Заяабал гишүүн, Батбаяр гишүүн, өөр хэн байна? Баясгалан гишүүн гурвыг дэмжсэнээр протоколд авъя. Аубакир гишүүний саналд бас Батбаяр гишүүн дэмжсэн юм байна.

Дамдинням гишүүний 2 дахь санал уу? Эрсдэлд орсон арилжааны банкнууд дахь Төрийн сан, Засгийн газрын тусгай зориулалтын сангууд болон төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн байршуулсан хөрөнгө эрсдэлд орсон талаар бас санхүүгийн гүйцэтгэлийн аудит хийлгэе гэсэн ийм санал байна.

Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 69.6 хувь дэмжигдсэн байна.

Батбаяр гишүүн, өөр? Гишүүнийг дэмжсэнээр авъя. Энэ санал дэмжигдээд жагсаалтад орохоор боллоо.

4 дэх санал Түвшин гишүүний гаргасан санал байна.

Энэ зөвхөн эрчим хүчний салбарт юм уу Түвшин гишүүн хаачив? Тэгвэл Түвшин гишүүнийхийг түр хойшлуулаад, дараагийн гишүүний саналыг хураалгачихъя. Бас Түвшин гишүүнийх байна. Бас Түвшин гишүүнийх байх юм. Түвшин гишүүн ээ тэр таны гаргасан 1 санал төрөөс эрчим хүчний салбарт баримталж буй бодлого, үнэ, тарифын зохицуулалтын өртөг, зардалд аудит хийх гэж мөн үү? Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

23 гишүүн санал хураалтдаа оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 65.2 хувь уг санал дэмжигдсэн.

Батбаяр гишүүн, Заяабал гишүүний саналыг дэмжсэнээр протоколд авъя.

Энэ зөв шүү. Одоо бид нар ингээд эрчим хүчний салбарыг үнийг чөлөөлье гээд байгаа юм. Энэ чинь монопол үйлдвэрийн үнэ чөлөөлнө гэдэг ойлголт байдаг байхгүй юу. Зүгээр эрчим хүчний салбарт бид нэг зүйлийг шаардах ёстой. Гадаад оронд эрчим хүчний жишээлбэл ТЭЦ 4 шиг ийм компани дээр хоёр, гурван зуун хүн л ажиллаж байгаа. Манайд мянган хүн ажиллаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ автоматжуулах, хүнийг цөөлөх, Эй Ай буюу тэр нөгөө хиймэл оюун ухааныг ашиглах энэ тэр гэсэн ийм юмнуудыг хийж өгөх хэрэгтэй. Дэд станц дээр хүн байхгүй. Манай дээр 10-уулаа л байж л байгаа. Тэгэхээр энэ юмнуудыг нь давхар шийдэж явахгүй бол энэ монопол үйлдвэрийн энэ үнэ, тарифын асуудлыг зүгээр чөлөөтэй явуулна гэх юм бол энэ ард түмний нуруун дээр давагдахгүй. Ер нь алдагдалгүй байх ёстой. Тэр хэмжээнд Эрчим хүчний зохицуулах хороо гэж байгаа байхгүй юу. Тэр нь л энийг нь хийгээд л явж байх ёстой болохоос биш үнийг нь чөлөөтэй хаяна гэдэг ойлголт бол байж болдоггүй. Тийм учраас энэ дээр энэ үнэ, тариф дээр нь аудит хийх нь зүйтэй.

5 дахь санал түвшин гишүүний гаргасан санал юм байна. Нефть боловсруулах үйлдвэрлэлийн үйл явц, зээлийн зарцуулалтад хяналт шалгалт хийх, аудит хийх гэсэн ийм санал юм байна. Энэ чинь тэгэхдээ шинээр барьж байгаа үйлдвэрийг хэлээд байна уу? Боловсруулах үйлдвэрийн ч гэж хэлэхгүй дээ. Тэгвэл энэ чинь баригдаж байгаа гэж ингэдэг ч юм уу тиймэрхүү юм оруулахгүй бол томъёолол нь арай бас болохгүй байна шүү тээ? Айн? Энэ чинь өөрөө л тайлбарлана. Өөр гишүүн тайлбарлахгүй юм байна лээ санал дээр. Болохгүй зөвхөн өөрөө. Өөрөө л тайлбарлана.

Түвшин гишүүн тэгвэл та татчих. Яах вэ, зээл дээр нь ашиглах, анхаарах юм байгаа шүү. Магадгүй ингээд зээл өгчхөөд одоо хэрэгжихгүй байгаад байгаа. Гэтэл бид нар зээлийн хүүг нь төлдөг байж магадгүй шүү.

Тийм учраас бас уг нь, ер нь үүнийг бас ингээд анхаараад бид нар ер нь тэр юун дээр үзэх юм байна гэж ойлголоо шүү. Тийм учраас ингээд зээл нь хэрэгжихгүй удаашраад л байдаг, бид нар хүү төлөөд л байдаг байж бас болохгүй.

Түвшин гишүүний микрофоныг өгье.

Б.Түвшин: Энэ нефть боловсруулах үйлдвэрийн явц нэгдүгээрт дуусаагүй, хоёрдугаарт ажлын хэсэг ажиллаж байгаа учраас энэ саналаа татъя.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн саналаа татлаа.

Дараагийн Түвшин гишүүний саналыг хураалгая. Энэ аудитын жагсаалтад үнэ тогтворжуулах зорилгоор төрөөс олгож буй тэр нөгөө зээлийн хүүгийн зөрүү тэгээд л янз бүрийн юмнууд олгоод байгаа шүү дээ. Олгож буй татаас нөхөн олговрын үйл явц, зарцуулалтын үр дүнд аудит хийлгэе гэсэн ийм санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжиж, 78.3 хувиар дэмжигдлээ.

Батбаяр гишүүн, өөр? Батбаяр гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Зургаа дахь санал Булгантуяа гишүүний гаргасан санал байна. Эм, эмийн хэрэгслийн агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд уу? Санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудит хийх гэсэн ийм санал юм байна.

Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ уг нь гүйцэтгэлийнх юм уу, эс үгүй бол бараг нийцлийнх. Гүйцэтгэлийнх л баймаар байх юм. Манай аудитынхны зүгээс ингээд байна л даа. Даргатай, даргагүй байж байж саяхан юу яасан, яг одоо өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт энэ тэр ер нь их агентлагийн дотроо их хэцүү байгаа юм байна. Үйл ажиллагаа нь их доголдолтой байгаа юм байна.

Тэгэхдээ бараг эсрэгээрээ түүнийг нь хэдүүлээ эртхэн шиг ярьж байсан нь дээр юм биш үү гэж бодоод байна л даа. Бид нар сая эмийн сонсголоос маш их үүрэг даалгавар өгсөн шүү дээ. Тийм, тэгье тэгэх үү? Тэгвэл гүйцэтгэлийн аудит болгочихъё. Тэгэх үү аудитынхан.

Ц.Даваасүрэн: Эм, эмийн хэрэгслийн агентлагийн үйл ажиллагаанд санхүү, гүйцэтгэлийн аудит хийх гэсэн Булгантуяа гишүүний гаргасан саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцсон 16 гишүүн дэмжиж 69.6 хувиар уг санал дэмжигдлээ.

Батбаяр гишүүний дэмжсэнээр авлаа. Батбаяр гишүүний тэр юуг үзээдхээч манай техникийнхэн. Энэ Мөнхсоёл гишүүн бас дэмжсэн юм байна, Баясгалан гишүүн бас дэмжсэн юм байна. Дэмжсэнээр авъя. Түвшин гишүүн бас дэмжсэн юм байна. Ингээд жагсаалтад орохоор боллоо. Одоохон би хамгийн сүүлд ярина.

Булгантуяа гишүүний санал байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүнд санхүү гүйцэтгэлийн аудит хийх үү?

Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Одоо бүх л төрлийн торгуулиуд яваад байгаа шүү дээ. Айн? Жишээлбэл замын зөрчлийн торгуулиуд хүртэл ороод байгаа байхгүй юу. Тэгэхдээ үүний орлогын төлөвлөлт биш орлого бол орж байгаа байх. Иргэдийн зүгээс бухимдаад байгаа нь зарцуулалт нь юунд зарцуулж байгаа юм бэ гэдэг дээр л бухимдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ гэмт хэрэг, зөрчлөө дахин гаргахгүй байх дээр, хохирогчийн эрх ашгийг хамгаалах дээр энэ мөнгө нь зарцуулагдаж байгаа юм уу, эс үгүй бол улсын төсвийн юунд орчхоод зүгээр тавилга, эд хогшил аваад байгаа юм уу гэдэгт л иргэд бухимдаад байгаа. Тэгэхээр түүн дээр л аудит. Тэгэхдээ нэг хэцүү нь байна шүү дээ энэ чинь нөгөө орон нутгийн сан руу орчихдог шүү дээ тээ? Төсөв рүү орчихдог шүү дээ. Тэгэхээр аймаг, нийслэл рүү орчихно гэсэн үг тийм ээ?

Тэгэхээр нэг хэцүү нь тийм бүх аймгуудынхыг үзэх ёстой ч юм шиг л харагдана. Тэгэхдээ нэг ийм нэгдсэн байдлаар та хэд ядаж жилд хэдийг ер нь орлогыг нь юу яагаад байгаа юм? Тэндээсээ жишээлбэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зарцуулдаг байхгүй юу Нийслэл гэхэд. Миний санаж байгаагаар бараг

3 жилийн өмнө 9 тэрбум орчим төгрөг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулж байсан. Тэгэхээр яг үүгээрээ яг юу хийж байгаа юм бэ? Буцаад гэмт хэргийг бууруулахын төлөө яг юу хийсэн юм бэ ч гэдэг юм уу иймэрхүү юман дээр нь аудит оруулж хармаар байх юм.

Ц.Даваасүрэн: Булгантуяа гишүүнээ энэ чинь хүү торгууль биш. Хураамж торгуулийнх юм байна. Тэгэхээр ингэе хураамж торгуулийн орлогын зарцуулалтад санхүүгийн аудит хийх юм байна шүү. Яаж зарцуулагдаж байгаа юм, юунд зарцуулагдаж байгаа юм гээд байгаа юм байна шүү дээ. Энэ томъёоллоор дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

4 номерын микрофон. 4 номерын микрофоныг өгчихье дөө. Хөөе энэ яая, сая яагаад надыг яагаагүй байхад алга болгочхов уу? Юу гэнэ?

Ц.Наранчимэг: Төсвийн тухай хуулиар санхүүгийн аудит маань өөрөө хуулийн цаглаварт хугацаатай учраас санхүүгийн аудит гэх юм бол бид хуулиар заагдсан байгууллага, нэршлээр аудит хийх болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас хүү торгуулийн орлогыг маань аймаг, нийслэл дэх ИТХ баталж, орон нутгийнхаа төсвийн хуваарилалтаар

Ц.Даваасүрэн: Энэ чинь Хураамжийн хуулийн дагуу явж байгаа юу хэлээд байгаа юм байгаа биз дээ? Хураамжийн хуулийн дагуу.

Ц.Наранчимэг: Тийм, хүү торгууль, хураамжийн орлого гээд хүү торгуулийн орлого гэсэн ийм нэртэй байгаад байгаа юм нэршил нь.

Тийм учраас үүнийг бүх аймгийн Төрийн аудитын газар нийслэлийн хэмжээнд үзэж байж нэгтгэл тайланг хийнэ. Гүйцэтгэлийн аудит юм уу, нэг бол энэ хуулийн хэрэгжилтийн нийцлийн аудит ч юм уу хийхээр болчихоод байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Төрийн хэрэгжилтийн нийцлийн аудит ч бай, түрүүний юунуудыг бүгдийг нь тэгж өөрчилье. Бүгд хуулийн хэрэгжилтийн байдаг юм уу, тэр үйл ажиллагааны гүйцэтгэлд нийцлийн аудит хийх нийцлийн аудит тээ? Бүгдийг нь ингэж өөрчилнө шүү. Ингэж тогтлоо.

Булгантуяа гишүүний санал дэмжигдсэн байна. Батбаяр гишүүн дэмжсэнээр авлаа.

Булгантуяа гишүүн юу гэнэ ээ? Баясгалан гишүүн, Мэндсайхан гишүүн нарыг бас дэмжсэнээр авах юм байна.

Булгантуяа гишүүн тайлбар хийе.

Х.Булгантуяа: Монголбанкны аудитын асуудлыг ингээд байна. Хуулиараа Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд ерөөсөө ордоггүй. Дээрээс нь нэмээд аудитаас зөвхөн сая Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн л аудит хийсэн юм байна. Ингээд хуулиар зөвхөн олон улсын аудитаар л аудитлагдана гээд ингээд тэгээд бид нар Төсвийн байнгын хороон дээр ер нь сонсож байгаагүй юм байна л даа угаасаа.

Тэгэхээр яах вэ үүнийг бид нар шууд аудит хий гэж оруулах гэхээр Монголбанкных нь хуулийг нь зөрчих гээд байдаг. Гэтэл нөгөө талдаа энэ чинь бас улсын төсвөөс санхүүждэг байгууллага. Хяналт, шалгалт, Улсын Их Хурлаас Улсын Хурлын харьяа байгууллага гэдэг утгаараа. Хяналт шалгалтын хуулиар л явахаас өөр аргагүй юм байна. Тэрнээс биш шууд Монголбанкны тухай хуулийг зөрчөөд аудитыг шууд аудитаар оруул гэж болохгүй юм байна.

Гэхдээ Үндэсний аудитын газраас өмнө нь угаасаа ийм зөвлөмж гарч байсан. Энэ бас нөгөө талдаа маш их өмч хөрөнгөтэй, төсөв санхүүтэй, хөрөнгө хүч ихтэй учраас энэ Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд оруулаач, аудит ордог болгооч жил болгон гэдэг ийм зөвлөмжийг хүргүүлж байсан юм байна.

Дээрээс нь би нөгөө түрүүн Хөгжлийн банкны гүйцэтгэлийн аудит гэж байсан. Энэ хийчхээд манай Улсын Их Хурлын руу хүргүүлчихсэн байгаа юм байна шүү? Тэгэхээр бид нар Төсвийн байнгын хороон дээрээ авч энийг хэлэлцэх ёстой юм байна.

Ц.Даваасүрэн: Тэгвэл би Байнгын хороо руу бас татчихъя. Хаана хүргүүлсэн юм та нар? Өмнө нь за за, тэгвэл тэрийг гишүүдэд би бас тараалгая. Тэр Хөгжлийн банкны зээлийн төлөлтийн асуудал дээр аудит хийгдсэн юм байна гэж.

Ингээд Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэсэн аудитын сэдэвт саяын зарчмын зөрүүтэй саналаар дэмжигдсэн саналуудыг нэмээд Аудитын тийм айн? Одоо нэгэнт нэмчихсэн юм чинь тэгээд л хий гээд эд нар чинь орон тоогоо нэмчихсэн байхгүй юу 180-аар. Асуудал байхгүй. Тийм учраас бол хэдүүлээ ачааллыг нь нэмнэ.

Аудитын сэдвийг батлах тухай саяын зарчмын зөрүүтэй саналуудыг тусгаад, Айн? Гараагүй шүү дээ. Хөөш ийм асуудал байна. Тэр хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалтад тусаж байгаа төслүүд байна шүү дээ. Энэ төслүүд дээр нийцлийн аудит хийж байж юу, төсөвт тусгадаг больё гээд байгаа юм байна лээ. Тэр ч бас жоохон төвөгтэй дээ тээ? Та нар хариулах уу айн? Үгүй үгүй наадах чинь нөгөө хэрэгжсэний чинь дараа, хэрэгжсэнээс нь мань хүн болохоор ингээд төсөвт тусгахаас нь өмнө нийцлийн аудит хийе гээд байхгүй юу. Тэгээд тэр бол их төвөгтэй л болох байх даа. Бүх жишээлбэл, хийгдсэн байгаа зураг төсвүүд байна шүү дээ. Нөгөө хөрөнгө оруулалтын зураг төсвүүдийг бүгдэд нь танайхаар аудит хийлгэж байж төсөвт тусгадаг больё гэсэн санаа.

4 номерын микрофон.

Ц.Наранчимэг: Төрийн аудитын байгууллагад 99 орон тоо нэмэгдсэн. Нөгөө гүйцэтгэл, нийцлийн аудит маань өөрөө стандартаараа үр дүн, үр нөлөөг үздэг маш тийм чухал хэрэгцээтэй ийм аудит байгаад байдаг. Тэгээд энийг стандартаараа хамгийн доод тал нь 3-6 сарын хугацаанд хийж тайлангаа хүргүүлж байж тэр сэдвийн аудит зөв болдог байгаад байгаа юм.

99 орон тооны бид нар 60 орон тоог аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газартаа орон тоог нь нэмж, доод тал нь 13-15 хүнтэй албан хаагчдаа ийм болгосон байгаад байгаа юм.

Ц.Даваасүрэн: Одоо нийт хэдэн хүнтэй болоо?

Ц.Наранчимэг: Тэгэхээр энэ аудитын гүйцэтгэл, нийцлийн аудитын сэдэв маань олон болчих юм бол бид нар нөгөө хүндээ тааруулаад нэг аудитын баг 5-6 хүнтэй байх ёстой. Өнөөдөр манай гүйцэтгэлийн аудитын газар маань 41 орон тоотой ажиллаж байгаа. Тэгэхээр энэ сэдвүүдээс бас аль сэдвийг нь хасах вэ, аль нь чухал вэ гэдгээ эрэмбэлэхгүй бол бид нар аудит хийж чадахгүй ийм байдалд хүрэхээр болчихоод байгааг анхаарч өгнө үү гэж Монгол Улсын Ерөнхий аудитортой ярилцаад энэ саналыг та бүхэнд хүлээж байна.

Ц.Даваасүрэн: Юу ч гэсэн ингээд саяын зарчмын зөрүүтэй саналуудыг тусгаад тэгээд санал хураалт явуулна.

Батжаргал гишүүн яах юм? Батжаргал гишүүн?

Ж.Батжаргал: Тийм ээ тухайлсан нэртэй, сэдэвтэй аудитууд байдаг. Бид хэд энэ нийгмээрээ жоохон энэ төсөв дээрээ анхаарал хандуулчихаад байгаа цаг үед энэ төсвийн тэлэлтийн чинь учир шалтгаан юундаа байгаа юм? Энийгээ бууруулах гэдэг юм уу, хурдсыг нь сааруулах, үр өгөөжтэй болгох тал дээр бид ер нь ямар арга хэмжээ авах юм гэдгийг хянаж үзмээр байгаад байгаа байхгүй юу. Нийцлийн аудит хийж үзмээр байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, тэр зураг, төсөв боловсруулж байгаа заавар, дүрэм, журмуудаа бүгдийг нь үзээд үнэхээрийн нийцэж байгаа юм уу, нийцэхгүй байгаа юм уу энэ заавар дүрмүүд чинь. Дээр нь энэ магадлал хийгээд байгаа юм чинь болж байгаа юм уу? Үүнийг зөв болгохын тулд ямар шийдэл гаргах ёстой юм гэдэг юмыг нь л тэрнээс би хийсэн магадлал болгоныг үз гэхгүй байна л даа. Үзэж байж төсөвт суулгая гэж ярихгүй байна. Хийгээд байгаа юмнуудыг нь нэг үзчихээд ямар зохицуулалт хийж байж илүү бодитой болох юм гэдэг юмаа харах нь зөв юм биш үү? Бид нарын өсөлтийн чинь гол зүйл энд байгаад байна л гэдэг үүднээс ийм 2 зүйлийг санаа агуулсан нэг нийцлийн аудитын асуудлыг төлөвлөгөөнд нэмж тусгуулах л санал байгаад байна л даа.

Ц.Даваасүрэн: Аудит саналаа Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлчихсэн юм байна. Хүргүүлчихсэн юм байна. Тийм учраас зүгээр наадхыг чинь хуулийн зохицуулалтын асуудал үүсчхээд байгаа байхгүй юу. Тийм учраас юу байж. Тийм учраас таны энэ гаргаад байгаа энэ асуудлыг энэ норм, норматив энд тусгай шаардлагуудыг нэг мөр болгох энэ асуудлуудыг хуулиар зохицуулах хэрэгтэй болчихоод байгаа байхгүй юу. Эд нар бол болохгүй байна гэдгийг нь бол бас аудитын дүгнэлт гаргаад Барилга, хот байгуулалтын яаманд ирүүлчихсэн юм байна лээ. Тэгээрэй дараа нь горимын санал.

Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Аудит аудит хийгээд санал, дүгнэлт холбогдох газруудад өгчихсөн юм бол Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны протоколд үүнийг тусгаад Төсвийн байнгын хороо холбогдох байгууллагуудынхаа төлөөллийг оруулсан ажлын хэсгээ гаргаж энэ асуудлаа зөв цэгцэд нь оруулах чиглэлээр ажиллацгаая. Тэгвэл би ийм чиглэлээр нь протоколд тусгаж өгөхийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Тэгье. Тэгээд Батжаргал гишүүнээр ахлуулаад энэ энэ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн энэ зураг, төсвийн зохиолд

экспертиз магадлан хийж байгаа энэ үйл ажиллагаатай хянаж нягтлах, шалгах ийм ажлын хэсэг байгуулъя.

Ганхуяг гишүүн горимын санал гэсэн тээ?

Х.Ганхуяг: Үгүй яах вэ энэ Батжаргал гишүүний ярьж байгаа юм агуулга зөв юм байгаа юм. Гэхдээ энэ чинь жишиг зургаар Улаанбаатарт барих, Өмнөговьд барих, Ховдод барих, Дорнод барих бүгдээрээ өөр өөр өртөгтэй байна угаасаа. Тэр чинь угаасаа барилгын материалын зардал нь өөр, ажиллах хүчний зардал нь өөр, дэд бүтэц нь, тээвэр нь, бүх юм нь өөр байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нийцлийн аудит хийгээд яг нэг төсвөөр та нар энд яг адилхан төсвөөр барь, тэнд яг адилхан төсвөөр гэдэг угаасаа боломжгүй байхгүй юу. Хэрвээ онцгой тэр нэмэгдэл байвал тэн дээр нь шалгалт хийж явна гэхээс биш нийцлийн аудит хийчхээд тэгээд хөрөнгө оруулалтын юмнуудаа явуулна гэх юм бид нар тэр бүтээн байгуулалтынхаа хугацаандаа юуг нь ч амжихгүй. Гэхдээ яах вэ энэ ажлын хэсэг нь ажиллаад тэн дээр санал, дүгнэлт гаргах нь зөв байх.

Ц.Даваасүрэн: Наадах чинь бүр дэг зөрчигдөх гээд байна. Нэг нэгнийхээ саналд тайлбар хийх ч маяг руу орох гээд байна. Болохгүй. Загджавын Мэндсайхан гишүүн.

З.Мэндсайхан: Дарга би санал байгаа юм Юун дээр Засгийн газрын тусгай сангууд дээр аудит оруулъя гэсэн шүү дээ. Тийм тэр дээр ийм юуг л, сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлээр явахаар нэлээн юм болчих байх. Гол асуудал юу байна вэ гэхээр зэрэг Засгийн газар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд сан дээр явж байгаа үйл ажиллагааны хүрээнд хөнгөлөлтүүдийг Засгийн газрын шийдвэрээр гаргаад явчихдаг. Ингээд сангаа алдагдалд оруулаад зүй нь бол нөгөө нөхөн дүүргэлтээ Засгийн газар чинь тэр хөнгөлөлтийнхөө хэмжээгээр сангийнхаа алдагдлыг хааж явах ёстой шүү дээ.

Тэгэхээр энэ шийдвэртэй холбоотой юмнууд жишээлбэл хөдөө аж ахуйн салбар дээр өвөлжилт, хаваржилт хүндрэнгүүт сангууд дээрх байгаа нөөцүүдээ Засгийн газар хуралдаанаараа шийдээд хөнгөлөлт үзүүлээд явчихдаг. 60 хувь, 70 хувь, 50 хувь ч гэдэг юм уу. Яг энэ хөнгөлсөн хэмжээгээрээ Засгийн газар өөрөө нөхөн дүүргэлтээ хийж явж байх ёстой. Энэнээс болоод сангууд алдагдалд ороод байдаг. Тэгэхээр яг сангийн энэ алдагдлыг нь Засгийн газартай холбоотой, нөхөн дүүргэлттэй холбоотой алдагдлыг аудитаар гаргаж ирэх нь зөв гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт, түрүүн Дамдинням гишүүн хөдөө аж ахуйн салбарын сангууд гэхээрээ тэнд зөвхөн ЖДҮ-ээс өөр сангүй болчихсон байхгүй юу. Тэгэхээр Хөдөө аж ахуйг дэмжих корпорацыг энэ үйл ажиллагаанд нь оруулъя гэж ийм л хоёр санал байна.

Ц.Даваасүрэн: Батлут гишүүн. Одоо ингээд зогсохгүй бол дэг арай зөрчигдөөд уналаа.

Д.Батлут: Яах вэ би түрүүн нөгөө асуусан л даа, 22 оны ажил, төсөл, хөтөлбөр, арга хэмжээн дээр аудит хийгээд зөрчил гарсан. Ямар үр дүн гаргасан юм бэ? Тэгээд тэр зөрчлийг арилгах тал дээр ямар арга хэмжээ авсан юм гэсэн надад ерөөсөө бодитой хариулт өгөөгүй. Тэгэхээр би энэ өөрийнхөө ярьж байгаа

зүйлийг татаж байна. Мэдээж бас хөрөнгө оруулалтын ажил хийхэд ч гэсэн нэлээн хүндрэлтэй болчих байх. Тэгэхээр ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байгаа. Саяын Батжаргал гишүүний ахлах ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байна. Тэгээд тэр ажлын хэсэг дээр орж ажиллаж байж асуудлууд асуудлууд тодорхой болж байж байж, дараагийн шийдлүүдийг гарах нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэгье. Би ажлын хэсэг байгуулахад Батлут гишүүнийг бас яая. Хэн, Мэндсайхан гишүүний хэлсэн саналыг алин дээр тусгах билээ? Хэн гишүүний гаргасан санал дээр байгаа билээ?

Дамдинням гишүүний гаргасан Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн яамны Засгийн газрын тусгай зориулалтын сангуудад сангийн үйл ажиллагаанд нийцлийн аудит хийе гэдэг дээр юу гэсэн санал гэлээ? Тэг хэлчих. Би хэлчихье, би хэлчихье. Тэрийг удирдамж дээр нь хийгээд явчихвал яадаг юм? Удирдамжид нь хийгээд явчихъя. Ямар корпорац гэнээ? Хөдөө аж ахуйг дэмжих корпорац гэдэг үгийг нэмье.

Энэ корпорац гэдэг үгийг нэмье гэдэг, Дамдинням гишүүний санал дээр корпорац гэдгийг нэмье гэдгээр хэдүүлээ санал хураалт явуулчихъя тэгэх үү? Корпорацыг нэмье гэж байна.

23 гишүүн санал хураалтад оролцсоноос 16 гишүүн дэмжиж, 69.6 хувиар дэмжигдсэн байна.

Батбаяр гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Гишүүд ээ, гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар санал хурааж дууслаа.

Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэсэн аудитын сэдэвт саяын дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг тусгаад аудитын сэдвийг батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 56.5 хувиар дэмжигдсэн байна.

Батлут гишүүн, Батбаяр гишүүн, Мэндсайхан гишүүн, Ганбаатар гишүүн нар дэмжсэнээр протоколд авлаа.

Хөөе болоогүй гишүүн ээ 3 дахь асуудал байгаа. Ингээд Аудитын сэдэв батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ. Дараагийн асуудалд оръё.

12.11 цаг

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Хуулиараа, хуулийг нь гаргаад ир дээ. Хуулийг нь би танилцуулаадахъя.

Хуулиараа Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг, би та бүхэнд хуулийн заалтыг нь бас танилцуулчихъя. Тогтоолын төслийг би та бүхэнд тараасан байгаа тиймээ? Тийм. Хөөш тогтоолын төсөл дээр зүгээр сар гэж байгаа. Сараар уу, 14 хоногоор уу харин? Сараараа явъя тээ? За за. 14 хоногоор болчихоод байгаа юм байна. Буцаагаад байгаа юм байна.

Яагаад гэвэл 14 хоногоор явуулчихаад дараа нь 14 хоногийн дотор бас нөгөө сонсгол хийх юм байна. Ондоо багтаах шаардлагатай болчихоод байгаа юм байна. Тийм учраас 14 хоногоор гээд тэгээд сонсгол хийх хугацааг нь бас 14 хоног нь оруулж өгөх хэрэгтэй болчихоод байгаа юм байна. Чи хуулийн заалтыг нь гаргаад ирээч. Хуулийн заалтыг нь.

Үгүй үгүй би хуулийн заалтыг нь та бүгдэд танилцуулах гэсэн байхгүй юу. Сонсгол нь угаасаа хуулиараа яваад байгаа юм байна. Хууль дээрээ байгаа юм байна лээ. Тийм.

Санхүүгийн зохицуулах хорооны тухай хуулийн 11.2-т хорооны даргад Улсын Их Хурлын дарга, гишүүдэд бид нар гишүүдийг ярих гэж байгаа байхгүй юу. Хорооны гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо 2 хүний Хууль зүйн байнгын хороо болон Төсвийн байнгын хороо 1 хүнийг, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 1 хүнийг, Монголбанкны Ерөнхийлөгч тус бүр 1, 1 хүнийг дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшин сонсгол хийж томилно гэж байна.

Тэгэхээр сонсгол хийж томилохоор байгаа байхгүй юу. Тэрний дагуу манай Байнгын хорооноос томилогдох 1 гишүүнийг нэр бүртгэх, сонгон шалгаруулалт хийх ийм тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийг Төсвийн байнгын хорооноос Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус 1 гишүүнийг дэвшүүлэх гэхээр заасны дагуу нэр дэвшигчийг бүртгэх тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа.

Тэгэхээр тэр тогтоолын төсөлд холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна.

Тэгвэл тогтоолын төсөл дээр байгаа тэр хугацааг 12 сарын 18-аар гэж өөрчлөөд ингээд явчихъя тэгэх үү? Тэгвэл байна шүү дээ ингэе. Тогтоолын төсөл дээр байгаа хугацааг 24 оны 12 сарын 18-аар болгоё гэдгийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулчихъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 15 гишүүн дэмжиж, 65.2 хувь дэмжигдсэн байна.

Батбаяр гишүүнийг дэмжсэнээр авлаа.

Одоо ингээд “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 23 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 69.6 хувиар уг санал тогтоол батлагдлаа.

Батбаяр гишүүнийг дэмжсэнээр авъя.

Хөөш “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны энэ тогтоолын төсөл дээр байна шүү дээ тээ ингээд одоо зарлагдана. Гишүүд бас нэр дэвшиж, санал болгох эрхтэй юм байна лээ шүү. Байнгын хорооны гишүүд. Нэр дэвшигчийг бүртгэж дууссаны дараа сонсгол явуулна. Гишүүд хэрвээ нэр дэвшүүлье гэж Байнгын хорооныхоо гишүүний эрхийн хүрээнд холбогдох нэр дэвшигчийнхээ нэрийг бүртгүүлэх шаардлагатай гэвэл Байнгын хороон дээр ирж бүртгүүлэх ёстой юм байна лээ.

Ингээд өнөөдөр бид нар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Баярлалаа гишүүд ээ.

12.15 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Д.ОТГОНДЭЛГЭР